

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ТӨРИЙН БАНК ХХК
(МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ)

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ТӨРИЙН БАНК ХХК

2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ТӨРИЙН БАНК ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗОРИУЛСАН
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

ТӨРИЙН БАНК ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: Буянтогтохын Нямаа
Санжаагийн Наранцогт
Батсэнгээгийн Доржсэмбэд
Ургамалын Бямбасүрэн
Пүрэвжавын Сайнзориг
Пүрэвбатбаатарын Билгүүн
Миширийн Батжаргал
Аюушийн Ганзориг

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Нямсүрэнгийн Анун

АЛБАН ХАЯГ: Төрийн Банк ХХК-ийн байр
Бага тойруу – 7/1, 1-р Хороо,
Чингэлтэй Дүүрэг,
Улаанбаатар-210644,
Монгол Улс

АУДИТОРУУД: Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАНК ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХХК-ийн (цаашид Банк гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ("ТУЗ") дарга Буянтогтохын Нямаа, Ерөнхий захирал Дашдондовын Баярсайхан, Гүйцэтгэх захирал Бадарчийн Цэндсүрэн болон Санхүү хариуцсан захирал Лхагвасүрэнгийн Чинбат, бид энэхүү тайлангийн 5–76 дугаар хуудсанд үзүүлсэн, Банкны санхүүгийн тайлангууд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



**БУЯНТОГТОХЫН
НЯМАА**

(ТУЗ-ийнн дарга)



**ДАШДОНДОВЫН
БАЯРСАЙХАН**

(Ерөнхий захирал)



**БАДАРЧИЙН
ЦЭНДСҮРЭН**

(Гүйцэтгэх захирал)




**ЛХАГВАСҮРЭНГИЙН
ЧИНБАТ**

(Санхүү хариуцсан захирал)

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: **15 MAR 2017**



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

Бид Төрийн Банк ХХК ("Банк")-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Эрнст энд Янг Монголия Аудит ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Ernst & Young Mongolia Audit LLC. Peter

ПЕТР МАРКИ

Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: **15 MAR 2017**

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2016 мян.төг	2015 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	3	223,356,438	217,531,759
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(154,851,909)	(143,432,189)
Хүүний цэвэр орлого		68,504,529	74,099,570
Шимтгэл, хураамжийн орлого	5	23,077,825	18,204,777
Шимтгэл, хураамжийн зардал	5	(2,472,159)	(1,824,158)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого		20,605,666	16,380,619
Арилжааны цэвэр олз	6	2,264,230	3,166,802
Үйл ажиллагааны бусад орлого	7	7,929,822	2,046,618
Үйл ажиллагааны нийт орлого		99,304,247	95,693,609
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	8	(15,131,685)	(10,373,713)
Үйл ажиллагааны цэвэр орлого		84,172,562	85,319,896
Үйл ажиллагааны зардал	9	(72,900,637)	(71,072,674)
Татварын өмнөх ашиг		11,271,925	14,247,222
Орлогын албан татварын зардал	10	(679,734)	(288,609)
Тайлант жилийн ашиг		10,592,191	13,958,613
Бусад дэлгэрэнгүй орлого			
<i>Дараагийн тайлант хугацаанд орлого эсвэл зардалруу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>			
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ</i>	25	451,477	4,042,314
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		11,043,668	18,000,927

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТӨРИЙН БАНК ХХК

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тодруулга		2016 мян.төг	2015 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	11	288,418,179	298,084,210
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	12	142,206,967	105,951,684
Урвуу репо хэлцэл	21	2,998,768	–
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	13	–	409,584
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14	1,128,995,688	924,447,474
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	15	427,619,291	220,733,145
Санхүүгийн хөрөнгө оруулалт – барьцаанд буй борлуулахад бэлэн	15	7,760,816	–
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусгавар хугацаа хүртэл эзэмших	15	–	59,200,835
Бусад хөрөнгө	16	12,778,559	12,709,945
Үндсэн хөрөнгө	17	78,914,811	79,242,236
Биет бус хөрөнгө	18	1,962,475	2,117,907
Хойшлогдсон татварын хөрөнгө	19	–	47,849
НИЙТ ХӨРӨНГӨ		2,091,655,554	1,702,944,869
ӨР ТӨЛБӨР			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	20	127,139,398	184,441,699
Репо хэлцэл	21	7,722,342	–
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	13	6,997	6,152
Харилцагчдын харилцах, хадгаламж	22	1,351,618,088	1,149,496,426
Зээлээр авсан санхүүжилт	23	351,859,125	192,669,107
Бусад өр төлбөр	24	7,190,858	6,818,266
Хойшлогдсон татварын өр төлбөр	19	561,859	–
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,846,098,667	1,533,431,650
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Энгийн хувьцаа	25	113,000,000	113,000,000
Бусад нөөц	25	16,691,594	16,702,043
Хоёрдогч өглөг	26	65,000,000	–
Хуримтлагдсан ашиг		50,865,293	39,811,176
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		245,556,887	169,513,219
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		2,091,655,554	1,702,944,869

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Энгийн хувьцаа	Бусад нөөц	Хуримтлагд- сан ашиг	Хоёрдогч өглөг	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2015.01.01-ний өдрийн байдлаар	113,000,000	13,767,142	24,745,150	–	151,512,292
Тайлант жилийн ашиг	–	–	13,958,613	–	13,958,613
Бусад дэлгэрэнгүй орлого	–	4,042,314	–	–	4,042,314
Нийт дэлгэрэнгүй орлого	–	4,042,314	13,958,613	–	18,000,927
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	–	(1,107,413)	1,107,413	–	–
2015.12.31-ний өдрийн байдлаар	113,000,000	16,702,043	39,811,176	–	169,513,219
Тайлант жилийн ашиг	–	–	10,592,191	–	10,592,191
Бусад дэлгэрэнгүй орлого	–	451,477	–	–	451,477
Нийт дэлгэрэнгүй орлого	–	451,477	10,592,191	–	11,043,668
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	–	(461,926)	461,926	–	–
Хоёрдогч өглөг	–	–	–	65,000,000	65,000,000
2016.12.31-ний өдрийн байдлаар	113,000,000	16,691,594	50,865,293	65,000,000	245,556,887

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТӨРИЙН БАНК ХХК

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Тодруулга	2016 мян.төг	2015 мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	11,271,925	14,247,222
Тохируулга:-		
Санхүүгийнүүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	410,430	(472,867)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын зардал	8 15,157,986	9,742,030
Бусад хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдал/(буцаалт)	8 (26,301)	631,683
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9 5,798,366	5,510,181
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9 1,086,826	870,620
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	9 62,414	148,062
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	9 1,915	—
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралт(буцаалт)	7 —	(93,931)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	33,763,561	30,583,000
<i>Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:</i>		
Монголбанкинд заавал байлгах нөөц	(35,473,539)	12,050,178
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	(70,012,570)	(305,275)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(156,976,600)	125,197,480
Бусад хөрөнгө	(42,313)	3,638,767
<i>Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	(57,302,302)	(118,559,560)
Репо хэлцэл	(3,037,242)	(138,527,454)
Харилцагчдын харилцах, хадгаламж	202,121,663	(17,737,208)
Бусад өр төлбөр	372,592	1,441,654
Үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(86,586,750)	(102,218,418)
Орлогын албан татварын төлөлт	(101,933)	—
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(86,688,683)	(102,218,418)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Тодруулга	2016 мян.төг	2015 мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө оруулалт	(58,604,285)	(5,128,183,420)
Дуусгавар болсон ба борлуулсан санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого	2,415,043	5,035,362,634
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	17 (5,533,355)	(10,771,356)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	18 (933,309)	(1,119,472)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(62,655,906)	(104,711,614)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээлээр авсан эх үүсвэрийн эргэн төлөлт	(89,123,620)	(151,949,841)
Зээлээр татсан эх үүсвэр	248,313,638	75,590,340
Санхүүгийн үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/-наас орсонцэвэр мөнгөн гүйлгээ	159,190,018	(76,359,501)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)	9,845,429	(283,289,533)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	274,295,882	557,585,415
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27 284,141,311	274,295,882

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**1. БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Тус банк нь Монголбанкнаас олгосон 26 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үндсэн үйлчилгээ үзүүлдэг. Тайлант жилийн хугацаа буюу 2016 онд Банкны үйл ажиллагаанд ямар нэг томоохон өөрчлөлт гараагүй.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Төрийн Банк ХХК-ийн байр, Бага тойруу-7/1, 1-р Хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот - 210644, Монгол Улс.

Банкны хувьцааны 24.779% -ийг Монгол улсын Сангийн яам болон 75.221% -ийг Монгол Улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци эзэмшдэг. Хадгаламжийн даатгалын корпорацийг Монгол Улсын Засгийн газар эзэмшдэг аж ахуйн нэгж бөгөөд банкинд саналын эрхгүй.

Төрийн Банк ХХК нь 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын шийдвэрийг үндэслэн Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээллэхийг зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО**2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ**

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх үүсмэл санхүүгийн хэрэгсэл, борлуулахад бэлэн, худалдах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө оруулалт болон үндсэн хөрөнгийг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Банкны үйл ажиллагааг Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Стандартыг хангасан байдал

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангаа хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайланг гаргасан өдрөөс хойш 12 сарын дотор (тогтмол) болон тайлагналт гарснаас хойш 12 сараас илүү хугацаанд (тогтмол бус) гарсан аливаа дахин тооцоо, төлбөртэй холбоотой шинжилгээг Тодруулга 32-д толилуулсан.

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэн бүртгэх хуулиар олгогдсон эрхтэй бөгөөд зөвхөн ирээдүйд гарч болзошгүй үйл явдлаас бусад доорх тохиолдлуудад санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй.

- Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед
- Дампуурал гарсан үед
- Банк эсвэл түүний хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан

Цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх баланст гол төлөв арилжаа, репо хэлцлүүд, клирингийн болон брокерын үлдэгдлүүд зэрэг орно. Дээрх шалгууруудыг хангаж буй нөхцөлд мөн дампуураагүй тохиолдолд мастер цэвэршүүлэлттэй үүсмэл хөрөнгө болон өр төлбөр нь зөвхөн цэвэршүүлсэн дүнгээр толилуулагдана.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн орлого зардал, хөрөнгө өр төлбөр, холбогдох тайлангийн тодруулга болон болзошгүй өр төлбөрийн дүнгүүдийг тодорхойлохдоо өөрсдөө үнэлгээ хийн, ойролцоолсон тооцоолуудыг хэрэглэдэг. Уг үнэлгээ, ойролцоолсон тооцоололд тодорхойгүй байдал үүссэн үед үр дүн нь дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд томоохон хэмжээний залруулга хийхэд хүргэдэг.

Тайлангийн өдрөөрх дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг хэмжээний залруулга хийхэд хүргэж болзошгүй өндөр эрсдэлтэй үнэлгээ, ойролцоолсон тооцооллуудыг дор үзүүлэв.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад ашигласан Банкны үнэлгээ, ойролцоо тооцоолол нь тодорхойлох боломжтой шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэсэн байдаг. Зах зээлийн өөрчлөлт, эсвэл Банкны хяналт тавих боломжгүй нөхцөл байдалд бий болсон өөрчлөлтүүдийн нөлөөллийн улмаас ирээдүйн төлөв байдлын талаарх одоогийн тооцоолол болон үнэлэмжинд өөрчлөлт орж болно.

Тасралтгүй үйл ажиллагаа

Банкны удирдлага Банкны тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд Банк нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Цаашилбал удирдлага нь банкны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдахуйц аливаа материаллаг тодорхойгүй үйл явдал гаргаагүй. Тиймээс, Банкны санхүүгийн тайлангуудыг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэнэ.

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогчид хөрөнгийг худалдахад хүлээн авах үнэ, өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ байна. Хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээ нь (эсвэл хамгийн ашигтай) зах зээлд (жишээ нь: эцсийн үнэ) тухайн үед тодорхойлогдсон үнэ бөгөөд тухайн үнэ нь шууд ажиглагдахуйц эсвэл үнэлгээний бусад арга техник ашиглаж тооцсон эсэхээс үл хамаарна. Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг идэвхтэй үйл ажиллагаатай зах зээл дээрээс олж мэдэх боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг зах зээлийн боломжит өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй байгаа тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо үнэлгээг хийх шаардлагатай болно. Үнэлгээ хийх болон тооцоолол хийхдээ төлбөрийн чадвар болон зээлийн эрсдэл (өөрийн болон харилцагч талын), санхүүжилтийн үнэ цэнийн залруулгууд тэдгээрийн хамаарал болон хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл хийн загварын өгөгдлүүдийг авч үзнэ. Бодит үнэ цэнийг тодорхойлох талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 30-д толилуулсан болно.

Үр ашигт хүүний түвшингийн арга (ҮАХ)

Банкны ҮАХ-ны аргачлал нь зээл болон хадгаламжийн талаарх хүлээгдэж буй тогтмол өгөөжийн талаар хийгдсэн хамгийн сайн үнэлгээг илэрхийлж чадах өгөөжийг ашиглан гаргасан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч мөн нөгөө талдаа бүтээгдэхүүний мөчлөгийн янз бүрийн үе шатанд тооцож болох боломжит янз бүрийн зээлийн хүүгийн (урьдчилгаа төлбөр болон торгуулын хүү болон төлбөрийг оруулаад) нөлөө болон бусад гарч болох шинж чанаруудын нөлөөг хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Энэ тооцоолол нь мөн чанараараа аливаа хэрэгслүүдийн мөчлөг болон хүлээгдэж буй шинж чанарын талаарх үнэлгээ гаргахыг шаарддаг бөгөөд үүнд Монголбанкны бодлогын хүүгийн гарч болох өөрчлөлт, тухайн хэрэгслээс үүсэх бусад хүү шимтгэлийн орлогын талаар өөрчлөлтүүдийг ч таамаглах болдог.

Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал

ТБанк нь өөрөө тайлагналтын өдрөөр томоохон хэмжээний зээл, урьдчилгааг дахин үнэлж, үнэ цэнийн бууралтыг үнэлэн орлогын тайландаа бүртгэх ёстой.

Банк нь хөрөнгө дээр үнэ цэнийн бууралтыг тооцохдоо хорогдсон өртөгөөр үнэлэн, санг дараах байдлаар бүртгэнэ:

- Дангаараа их хэмжээтэй эсвэл тусгайлан тодорхойлсон зээлд тусгай үнэлгээний алдагдал
- Дангаараа их хэмжээтэй бус эсвэл тусгайлан тодорхойлогдоогүй зээлд бүлгийн үнэ цэнийн алдагдал

Ангилал бүрийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийн дүн, эргэн төлөгдөх хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлгээ шаардагддаг. Эдгээр тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн таамаглалууд дээр үндэслэдэг бөгөөд янз бүрийн үр дүнд хүрч, өөрчлөгдөж байдаг.

Түүнчлэн, бүлгийн үнэлгээг хийхэд ашиглагдах өгөгдөл болон тооцоонд цөөн тооны нэг төрлийн багцыг тодорхойлон шалгуур үзүүлэлт гаргах, эрсдэлийн төвлөрөлийн нөлөөг гаргах, эдийн засгийн тоо мэдээллийн (эргэн төлөлтийн хандлага, орон сууцны зээлийн үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс зэрэг

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

барьцааны үнэ цэнийн тооцоолол, тухайн улсын эрсдэл, салбаруудын гүйцэтгэл, дампуурлын хандлага) нөлөө болон гэнэтийн нөхцөл байдалд тооцоолох шалгуур үзүүлэлтүүд ч орно. Тухайн аргачлал болон түүнд ашигласан таамаглалыг бодит алдагдлыг хүлээн зөвшөөрсний дараа байнга дахин тооцоолж байх хэрэгтэй.

Зээл, урьдчилгаануудын үнэ цэнийн бууралтын алдагдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 8, 14, 29-д толилуулсан болно.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Банк нь өрийн үнэт цааснуудыг “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт” гэж ангилан Тодруулга 29-н дагуу тайлагналтын өдрөөр үнэ цэнийн бууралтанд орсон эсэхийг үнэлдэг.

Энэ үнэ цэнийн бууралтыг тооцохдоо ирээдүйн мөнгөн урсгал болон дискаунтчилагдсан мөнгөн урсгалын загварын бусад өгөгдлүүд болон өмчийн хэрэгслүүдийн хувьд, “Их хэмжээ”, “Урт хугацаа” гэдгийг тодорхойлохшаардлагатай болно. Энэ үнэлгээг хийхдээ Банк нь хувьцааны үнийн өөрчлөлтийн түүх, хөдөлгөөн, тухайн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө ямар хугацаанд, ямар хэмжээгээр бага байсан зэрэг үзүүлэлтийг тооцно.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Банк нь өөрийн газар болон барилгыг дахин үнэлгээгээр хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод(БДО) бүртгэдэг. 2013 онд Банк нь хөрөнгийн үнэлгээний хараат бус компанитай гэрээ байгуулж өөрийн барилгуудыг үнэлүүлсэн. Үнэлгээнд зах зээл дээр борлогдсон ижил төсөөтэй барилгуудын үнийг байршил, шинж чанар, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн хүчин зүйлүүдээр тохируулсан үнийг суурь үнэ болгон ашигласан. 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар удирдлага нь барилгын бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнгээсээ их хэмжээгээр өөрчлөгдөөгүй гэж үзсэн. Уг үнэлгээнд тухайн хөрөнгөтэй холбоотой туршлага болон Тодруулга 30-д толилуулсан төсөөлөлд суурилсан удирдлагын үнэлэмжийг шаардсан.

Хойшлогдсон татварын хөрөнгө

Алдагдлыг ашиглах боломжтой татвар ногдох ашиг олох бололцоотой болсон үед татварын алдагдал дээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд олох татвар ногдох ашгийн хугацаа, хэмжээ ба ирээдүйн татвар төлөвлөлтийн стратеги зэрэг дээр үндэслэн хойшлогдсон татварын хөрөнгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай.

Сангууд болон болзошгүй өр төлбөр

Банк нь хууль эрх зүйн зохицуулалтын орчинд үйл ажиллагаагаа явуулдаг ба үйл ажиллагаанаасаа хамаарч шүүхийн зарга маргааны эрсдэлд орох боломжтой байдаг. Үүний үр дүнд, Банк өөрийн ердийн үйл ажиллагааныхаа явцад үүссэн төрөл бүрийн шүүхийн болон арбитрын хэргийн байцаалтанд Монгол улсад мөрдөгдөж буй хууль журмын хүрээнд оролцож байна.

Банк нь аливаа шүүхийн маргаантай хэргээс үүсэх магадлалтай хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолж түүнд ногдох үнэ цэнийн бууралтын санг тухай бүрт нь байгуулдаг. Хохирлын хэмжээг зохистойгоор үнэлэх боломжгүй эсвэл хохирол үүсч болох магадлал нь тодорхойгүй тохиолдолд Банк үүнийг болзошгүй өр төлбөр хэмээн толилуулдаг.

Гэсэн хэдий ч Банк дээрх тооцооллуудыг маргаантай хэрэг тус бүрээр толилуулах нь тухайн хэргийн үр дүнд сөргөөр нөлөөлж болно гэсэн байр суурьтай байдаг тул санхүүгийн тайландаа хэрэг тус бүрээрх дэлгэрэнгүй тодруулгуудыг толилуулдаггүй.

Банк нь учирч болох алдагдлын хэмжээ, үүсэх магадлал болон тодорхой бус байдлыг харгалзан мэргэжлийн зөвлөгөө авах, хэргийн үе шат болон адил төсөөтэй хэргийн түүхэн баримтууд цуглуулах зэрэг бусад арга хэмжээг авч ажилладаг. Эдгээр тооцооллыг хийхэд ихээхэн үнэлэмж шаарддаг. Үнэ цэнийн бууралтын сан болон бусад болзошгүй өр төлбөрийн талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 28-с үзнэ үү.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БА ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорхи СТОУС-ууд болон нэмэлт өөрчлөлтүүдээс гадна Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна.

Шинэ болон нэмэлт өөрчлөлтүүдийн стандартууд

• СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС28 нэмэлт өөрчлөлт	Хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд: Нэгтгэлд үл хамаарлыг хэрэгжүүлэх
• СТОУС 11 нэмэлт өөрчлөлт	Хамтарсан хэлцэл – Хамтын үйл ажиллагаан дах хувь оролцоо эзэмших үеийн бүртгэл
• СТОУС 14	Зохицуулалтын хойшлогдсон дансууд
• НББОУС 1, нэмэлт өөрчлөлт	Тодруулгын санаачлагууд
• НББОУС 16, СТОУС 38 нэмэлт өөрчлөлт	Элэгдэл ба хорогдуулгын хүлээн зөвшөөрөгдөх аргуудын тодруулга
• НББОУС 16, СТОУС 41 нэмэлт өөрчлөлт	Үндсэн хөрөнгө – Үрт ургамал
• НББОУС 27, нэмэлт өөрчлөлт	Тусдаа санхүүгийн тайлангууд: Тусдаа санхүүгийн тайлан дах Өмчийн арга
• Жилийн сайжруулалтууд	2014 оны 9 сард гарсан СТОУС-уудын хэд хэдхэн нэмэлт өөрчлөлтүүд

Шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон СТОУС-ын өөрчлөлт нь банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн байдал болон гүйцэтгэлд томоохон нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

• НББОУС 7, нэмэлт өөрчлөлт	Тодруулгын санаачлага ¹
• НББОУС 12, нэмэлт өөрчлөлт	Орлогын татвар: Хэрэгжээгүй алдагдалд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ¹
• СТОУС 2, нэмэлт өөрчлөлт	Хувьцаанд суурилсан төлбөр хийх ажил гүйлгээний ангилал болон хэмжилт ²
• СТОУС 4, нэмэлт өөрчлөлт	СТОУС 4 Даатгалын гэрээнүүдтэй санхүүгийн хэрэгслүүд ²
• НББОУС 40, нэмэлт өөрчлөлт	Хөрөнгө оруулалтын хөрөнгийн шилжүүлэлт ²
• СТОУС 10, НББОУС 28 нэмэлт өөрчлөлт	Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүд: Хөрөнгө оруулагч болон түүний Хараат компани эсвэл Хамтарсан хэлцэл хооронд Хөрөнгө борлуулах эсвэл оруулах ⁴
• СТОУС 9	Санхүүгийн хэрэгсэл ²
• СТОУС 15	Харилцагчтай байгуулсан гэрээний орлого ²
• СТОУС 16	Түрээс ³
• СТОУТХ 22-н тайлбар	Гадаад валютын гүйлгээ болон урьдчилсан хэлэлцүүлэг ²
• Жилийн сайжруулалтууд (2014-2016)	2016 оны 12 сард гарсан СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд ¹

¹ 2017 оны 1 сарын 1- ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

² 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

³ 2019 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁴ Хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг хараахан тусгаагүй боловч дагаж мөрдөх боломжтой.

Банк нь эдгээр стандарт болон тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөхөд санхүүгийн тайландаа нөлөө үзүүлж байгаа эсэхийг үнэлж байна.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО****(1) Гадаад валютыг хөрвүүлэх**

Банкны үйл ажиллагаанд хэрэглэгдэх мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээг хийсэн өдрийн спот ханшаар бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналтын өдөрт тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн спот ханшаар дахин хөрвүүлж оруулдаг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагааны бусад орлого/зарлагаар хүлээн зөвшөөрнө.

Түүхэн өртөгөөр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлийг хүлээн зөвшөөрөх өдрийн спот ханшаар хөрвүүлнэ.

Төгрөгийн нэгж ам доллартай харьцах ханш 2016 оны 12 сарын 31 болон 2015 оны 12 сарын 31-ний өдрүүдийн байдлаар харгалзан 2,489.53 төгрөг болон 1,995.98 төгрөг байв.

(2) Санхүүгийн хэрэгсэл – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараах хэмжилт

Санхүүгийн хэрэгсэл гэдэг нь нэг компанийн санхүүгийн хөрөнгийг өөр компанийн санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэгсэлээр өсгөж харуулдаг аливаа гэрээ хэлцлийг хэлдэг.

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Банк нь харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Банк тухайн хэрэгслийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах хадгаламжийн өр төлбөрийг хөрөнгө Банкинд шилжсэнээр хүлээн зөвшөөрнө.

(ii) Санхүүгийн хэрэгслийн анхны хэмжилт

Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт нь тухайн хэрэгслийн зорилго, онцлог мөн удирдлагын уг хэрэгслийг олж авах болсон зорилгоос хамааран ангилалддаг. Бодит үнэ цэнэ нь орлогын тайланд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэгслүүдийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэгслүүд

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн хэрэгсэл эсвэл бусад гэрээ байхын тулд дараах шинж чанаруудыг бүгдийг агуулдаг:

А) Үнэ цэнэ нь тодорхой хүүний түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьцагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол

Б) Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил байдлаар хандахаар хүлээгдэж буй адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол

В) Ирээдүйд төлөгдөхөөр бол

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлүүд хийдэг. Эдгээр нь, хүүгийн болон кросс ханшийн своп, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

(iv) Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр

Банк нь арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийг худалдан авах эсвэл арилжааны үйл ажиллагаагаар богино хугацааны ашиг олох зорилгоор анх авсан, эсвэл богино хугацаанд ашиг олох нь нотлогдохуйц багц санхүүгийн хэрэгслүүдийн хэлбэрээр олж авсан үеүдэд “худалдах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр гэж ангилдаг. “Худалдах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусгана. Хүүний болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь орлого, зардлын дансанд бүртгэнэ. Энэ ангилалд ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа өрийн үнэт цаас, энгийн хувьцаа, өөрийн хөрөнгө, богино позицууд болон харилцагчдын зээл орсон.

(v) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Энэ бүлгийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь удирдлага анх хүлээн зөвшөөрөхдөө энэ бүлэгт оруулахаар шийдвэрлэсэн санхүүгийн хэрэгслүүд байна.

2016 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөргүй байна.

(vi) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн гэж ангилагдсан хөрөнгө оруулалтуудад өөрийн хөрөнгө болон өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалтууд багтана. “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” ба “бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэсэн ангилалд ороогүй өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг “Борлуулахад бэлэн” гэж ангилна. Тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас борлуулж болох өрийн үнэт цаасууд энэ ангилалд орно. Банк нь аливаа зээл, авлагуудыг “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Анхны хэмжилтийн дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Бодит бус олз ба гарзыг (БДО) “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлогын тайланд үйл ажиллагааны бусад орлогоор хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагдах” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүний орлогыг тухайн хэрэгслийн өгөөжийн салшгүй хэсэг болох хөнгөлөлт/урамшуулал болон холбогдох зардлыг харгалзан үзсэн үр ашигт хүүний аргыг ашиглан хүүний орлогоор бүртгэнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлогын тайланд үйл ажиллагааны бусад орлогоор хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайлангийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө. “Борлуулахад бэлэн” хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 29-с үзнэ үү.

vii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтоосон хугацаатай, Банк дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай, үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт” гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүний арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайлангийн “Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрнө.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хэрэв Банк бага биш дүнтэй “дуусгавар хугацаа хүртэл эзэмших” хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас нь өмнө худалдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь “борлуулахад бэлэн” бүлэгт дахин ангилна. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд аливаа нэг санхүүгийн хөрөнгийг “дуусгавар хугацаа хүртэл эзэмших” бүлэгт ангилахыг хориглодог.

(viii) Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж болон харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа

Энд идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөртэй дараахаас бусад, “Бусад банкин дахь харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа” гэсэн үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд багтана. Үүнд:

- Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүд;
- Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүд;
- Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэгслүүд.

Анхны хэмжилтийн дараа “Бусад банкин дахь харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа”-г үр ашигт хүүний аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайланд “Зээлийн үнэ цэнийн бууралт”-ын алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Банк зээлийг хадгалж үлдэх хандлагатай байгаа ба богино хугацаанд худалдахгүй гэсэн амлалт гаргасан бол энэ амлалтыг хэрэгжүүлэх нь төвөгтэй ба алдагдал хүлээх магадлалтай үед л энэ амлалтыг бүртгэнэ.

(ix) Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан эх үүсвэр

Зээлээр авсан эх үүсвэр нь гадаад дотоодын санхүүгийн байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргийг хэлнэ.

Анхны хэмжилтийн дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо гүйлгээтэй холбоотой аливаа зардлуудыг харгалзан үзсэн үр ашигт хүүний аргаар тооцно. Банкны зээлээр авсан эх үүсвэрүүдийн шинжилгээг Тодруулга 23-д толилуулсан.

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг эсвэл үүнээс өөр аргаар өөрийн өр төлбөрийг барагдуулах үүргийг Банкнд үүсгэж байгаа үед, Банкнаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” болон “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэгслүүдийг “Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан бусад эх үүсвэр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна.

Анхны хэмжилтийн дараа гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан бусад эх үүсвэрийг үр ашигт хүүний аргаар хорогдуулсан өртгийн дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо худалдан авах үед үзүүлсэн аливаа нэг хөнгөлөлт эсвэл урамшуулал ба үр ашигт хүүний салшгүй хэсэг болсон холбогдох зардлыг авч үзнэ.Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэгсэл нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэгслүүд болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-н дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Банк нь санхүүгийн хэрэгслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банкнд санхүүгийн

ер төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэгслийг эзэмшигчид, хэрэгслийг Банкны өөрийн хөрөнгийн хэрэгсэлд хөрвөх бололцоо өгч байвал. Хөрвөх хэрэгслийн ер төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон ер төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэгслийн нийт бодит үнэ цэнээс ер төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэгсэлд агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэгслийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) ер төлбөрийн бүрэлдэхүүнд багтана. Банк нь тухайн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон ер төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг салгах гэж буй бол тухайн ер төлбөрт салгах шаардлагатай агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл байгаа эсэхийг үнэлнэ. Банк нь агуулагч гэрээ болон дансдаас агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг зөвхөн доорх нөхцөлд салгана:

- Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанар нь агуулагч гэрээний эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанартай нягт холбоотой биш үед
- Агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй ижил нөхцөлтэй салангид хэрэгсэл нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн тодорхойлолтыг хангаж буй тохиолдолд
- холимог (нэгтгэсэн) хэрэгсэл нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдсэн өөрчлөлттэйгээ бодит үнэ цэнээрээ бүртгэгддэггүй (жишээ нь, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө эсвэл ер төлбөрт агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй зээлээр авсан эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөр бүртгэх хоёрдогч өглөгөөр толилуулсан. (Тодруулга 26)

(х) Харилцагчдын харилцах, хадгаламж

Үүнд харилцагчдаас авсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон банкны баталгааны эх үүсвэр хамаарна. (Тодруулга 22)

Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх ер төлбөрүүдийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

(хи) Бусад санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

Бусад банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд үүнд хамаарна (Тодруулга 20). Банк нь, харилцагчдийн харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь Банкинд шилсэн үед хүлээн зөвшөөрдөг.

Анхны хэмжилтийн дараа бусад банкуудад өгөх ер төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

(хii) “Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээлийн ажил гүйлгээний бодит үнэ цэнээс ялгаатай эсвэл нээлттэй зах зээлийн мэдээллийн үнэлгээний аргад суурилсан байвал Банк бодит үнэ цэнэ, ажил гүйлгээний зөрүүг нэн даруй бусад үйл ажиллагааны цэвэр орлогоор хүлээн зөвшөөрнө (Эхний өдрийн ашиг ба алдагдал). Илэрхий нээлттэй мэдээлэлд суурилагүй бол ажил гүйлгээний үнэ болон үнэлгээний загварын зөрүүг орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**(xiii) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал**

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд бүртгэсэн аливаа нэг олз гарзыг хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүний аргаар хорогдуулж, орлого, зардлын дансанд бүртгэнэ. Хорогдуулсан шинэ үнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хоорондох аливаа нэг зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүний аргаар хорогдуулна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж тодорхойлбол өмнөх хугацаанд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн дүнг дэлгэрэнгүй орлогын тайлан руу шилжүүлэн бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл, авлагын тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хандлагатай ба эзэмших чадвартай байгаа бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Худалдах зорилгоор эзэмшиж буй” гэсэн ангиллаас “Зээл ба авлага” гэсэн ангилалд дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан ба орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүний түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэгсэл тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэгслийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” бүлэгт дахин ангилахгүй.

(3) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт**(i) Санхүүгийн хөрөнгө**

Банк санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
 - “Дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн
- “Дамжуулан өнгөрөөх” хэлцэл нь Банк тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл биелж байх нөхцөлд гэрээний үүргийн дагуу тэдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ.
- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр зах зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн авах эрхтэй богино хугацаат урьдчилгааг оруулалгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно.
 - Банк нь эцсийн хүлээн авагчдаас мөнгөн урсгал хүлээн авахын тулд үнэт цааснаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй.
 - Банк нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг удаан хугацаагаар саатуулалгүйгээр шилжүүлэх үүрэгтэй. Үүнээс гадна, Банк нь тэдгээр мөнгөн урсгалыг, цуглуулсан өдрөөс шаардлагатай гуйвуулгын өдөр хүртэлх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө оруулалт хийсэн богино тооцооны хугацаанаас бусад үед дахин хөрөнгө оруулалтанд оруулахгүй бөгөөд тэдгээр хөрөнгө оруулалтуудаас үүссэн хүү нь эцсийн хүлээн авагчид шилжинэ.

Дамжуулалтыг зөвхөн доорх нөхцлүүдээс хангасан тохиолдолдүл хүлээн зөвшөөрнө:

- ▶ Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- ▶ Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнхи эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(4) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл (“repo”)-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнхи эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгөө хөрөнгөөр, repo хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тус тус тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Нөгөө тал нь үнэт цаасыг худалдах эсвэл дахин барьцаалах эрхтэй бол, Банк нь тухайн үнэт цаасуудыг санхүүгийн байдлын тайландаа борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө эсвэл борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө оруулалтын аль тохиромжтой ангилалд үлдээнэ.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл (“урвуу repo”)-ийн дор худалдан авсан үнэт цаасуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүний хамт тайлан тэнцэлд “Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа” гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг “Хүү болон түүнтэй адилтгах орлого” гэж бүртгэх ба үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Хэрэв буцаан худалдах хэлцлээр худалдан авсан үнэт цаасыг гуравдагч талд худалдсан бол үнэт цаасыг буцаан өгөх үүргийг “Худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр” гэж бүртгэх ба бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн аливаа олз эсвэл гарзыг “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэнэ.

(5) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Банк нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- **Түвшин 1- санхүүгийн хэрэгслүүд**

Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ. Банк нь хэмжээ болон төлбөрийн чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ

- **Түвшин 2- санхүүгийн хэрэгслүүд**

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь, санхүүгийн хэрэгслийн амьдралын мөчлөгийн туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх адил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх адил төстэй хэрэгслийн үнэ болон үнэнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, харгалзах хэлбэлзэл болон зээлийн эрсдэлийн үнэ гэх үэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн нөхцөл байдал болон байршил мөн харьцуулах зүйлсийн аль нь үнэлэгдсэн хэрэгсэлтэй холбогдох зэргээс залруулга шаардлагатай байж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэнд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэгслүүдийг Түвшин 3-р ангилна.

• Түвшин 3- санхүүгийн хэрэгслүүд

Эдгээрт, хэмжилтийн бүхэлд нь чухад ач холбогдолтой, нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

Банк нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдцотой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Тайлант хугацааны эцэс бүрт Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг (бодит үнэ цэнийн хэмжилтэнд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн).

Хөрөнгийг үнэлэхэд гадны үнэлгээчдийг оролцуулж болно. Гадны үнэлгээчдийг сонгохдоо зах зээлийн мэдлэг, нэр хүнд, хараат бус байдал болон мэргэжлийн стандарт хангасан эсэх гэх мэт шалгууруудад үндэслэдэг.

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг тодруулга 30-д тусгасан.

(6) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгийн хувьд Банк эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийгнийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь

хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулахдаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүгийн хувиар тооцон хуримтлуулна. Хүүний орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ.

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед, зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Өмнөх жилүүдэд данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл, төлөгдсөн тайлант үеийн “бусад үйл ажиллагааны орлого”-оор бүртгэнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах нөхцөлтэй байх, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Банк арилжааны зориулалттай хөрөнгийг “Зээл ба авлага” ангилалд дахин ангилсан бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь дахин ангилсан өдрийн шинэ үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтын бүлгийн үнэлгээгээр үнэлгээг санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн банкны дотооддоо хэрэглэдэг зээлийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ.

Банк нь эрсдэлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэлд нь хувааж үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох энгийн аргачлалыг сонгосон. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ. Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил бүрийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлын түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын дэлгэрэнгүйг тодруулга 8-аас, зээл ба авлагын ангилал тус бүрээрх алдагдлаас хамгаалах сангийн шинжилгээг тодруулга 14-аас тус тус харна уу.

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө орлуулалт

Банк нь “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт”-ын үнэ цэнийн бууралтанд орсон эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үздэг. Борлуулахад бэлэн гэж ангилагдсан өрийн хэрэгслүүдийн хувьд Банк нь үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгана:

Банкны бүх мөнгөн гүйлгээгээ эргэн авах чадварт нөлөөлөх тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгал эсвэлсуурь барьцаа (хөрөнгө барьцаалсан үнэт цаасны хувьд, Банк нь төлөгдөөгүй үлдэгдлийг үндсэн барьцаанаас төлүүлнэ гэж үзэж буй тохиолдолд)-нд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болсон эсэхийг үнэлнэ. Үнэ цэнийн бууралтаар бүртгэгдэх дүн нь

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх хуримтлагдсан алдагдлын дүн байна. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд орлогын тайланд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өсөж эсвэл буурвал, үнэ цэнийн бууралтын алдагдлыг орлогын тайлангаар дамжуулан буцаана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд, бодит нотолгоонд доорх багтана:

- Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө “их хэмжээгээр” эсвэл “урт хугацаанд” тогтмол буурч байвал, эсвэл,
- Өмч гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болохуйц бусад мэдээлэл

Банк нь “их хэмжээгээр” гэж ихэвчлэн 20%-р, “урт хугацаанд” гэж ихэвчлэн зургаагаас дээш сар гэж авч үздэг. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

“Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 29-с үзнэ үү

(iii) Зээлийн шинэчилсэн гэрээ

Зээлийн нөхцлийг өөрчлөхдөө хэд хэдэн аргыг ашиглаж болдог. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол аливаа нэг үнэ цэнийн бууралтыг зээлийн нөхцлийг өөрчлөхөөс өмнө тооцож байсны нэг адил анхны үр ашигт хүүний аргыг ашиглан хэмжих ба зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүний хувиар тооцдог тусгайлсан болон багцын үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байна.

(iv) Хураан авсан барьцаа хөрөнгө

Хураан авсан барьцаа хөрөнгө нь уг хөрөнгийг бүртгэсэн өдрөөрх холбогдох зээлийн үлдэгдлийн хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүнгийн аль багаар анхлан хүлээн зөвшөөрдөг ба холбогдох зээл болон урьдчилгаа мөн тэдгээрийн үнэ цэнийн бууралтын санг балансын бүртгэлээс хасдаг. Дараагийн тайлант үеүдэд, хураан авсан барьцаа хөрөнгийг өртөг болон бодит үнэ цэнээс түүний борлуулахтай холбоотой гарах зардлыг хассан дүнгийн аль багаар бүртгэдэг ба эдгээр хөрөнгүүд нь тайланд бусад хөрөнгө хэсэгт тайлагнагддаг.

(7) Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээний биелэлт нь тухайн хөрөнгө эсвэл хөрөнгүүдийн ашиглалтаас хамаарах эсэх, гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Банк түрээслэгч

Банкинд түрээслэж байгаа хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлэхгүй байгаа тохиолдолд түрээсийн гэрээ нь үйл ажиллагааны түрээс байна. Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ. Болзошгүй түрээсийн төлбөрийн өр төлбөрийг бий болсон тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Банк түрээслүүлэгч

Банк нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаа

түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээслэсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө. Болзошгүй түрээсийн төлбөрийн орлогыг бий болсон тайлант хугацаанд нь орлогоор хүлээн зөвшөөрнө

(8) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой болсон хэмжээгээр, найдвартайгаар хэмжиж болох үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

(i) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэгслүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгө, “Бодит үнэ цэнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүний орлого, зардлыг үр ашигт хүүний хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) ашиглан бүртгэнэ. Тооцоололд санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэгсэлд шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас бууруулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахдаа хэрэглэсэн хүүний түвшинг ашиглан хүүний орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

(ii) Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамжийн орлогыг дараах гурван бүлэгт хувааж болно. Үүнд:

Тодорхой хугацааны туршид үзүүлж байгаа үйлчилгээнүүдээс олсон хураамжийн орлого.

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжинд шимтгэлийн орлого, хөрөнгийн удирдлага, хамгаалалтын болон бусад удирдлага, зөвлөгөөний хураамжууд орно.

Гүйлгээний үйлчилгээний хураамжийн орлого

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсвэл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

Холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого

Банкны холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, татан авагдах магадлалтай зээлүүд дээр зээлийн үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) зээлийн үр ашигт хүүний залруулга гэж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэл нь хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. НББОУС 39-ийн хүрээнд зээлийн үүргийн шимтгэлүүд нь (“Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх” гэж тодорхойлогдоогүй, эсвэл зах зээлийн хүүгийн түвшингээс бага, эсвэл цэврээр илэрхийлэгдсэн бол) үүсмэл санхүүгийн хэрэгсэл гэж бүртгэн бодит үнэ цэнээр нь хэмжин зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

(iii) Арилжааны цэвэр орлого

Арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үр дүнд санхүүгийн үүсмэл хэрэгслийг багтаасан, “Худалдах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс үүсэлтэй олз, гарзууд багтана.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**(9) Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайланд зааснаар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь мөнгө, Монголбанкн дахь хязгаарлалтгүй харилцах данс, бусад банкн дахь харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

(10) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг. Хөрөнгийн хорогдуулах хугацаа эсвэл элэгдүүлэх аргад өөрчлөлт орсноор хөрөнгийн ашиглалтын хугацаанд өөрчлөлт орсон гэж үзэх ба зохистой гэж үзвэл нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Газрыг элэгдүүлэхгүй. Үндсэн хөрөнгийн ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааг доор үзүүлэв.

Барилга	40 жил
Компьютер техник хэрэгсэл	3 жил
Тавилга, тоног төхөөрөмж	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил

Харилцагчаас шилжүүлсэн хөрөнгийг анхлан тухайн хөрөнгийн хяналтыг авсан өдөр бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Газар ба барилгыг дараагийн тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдэл болон үнэлгээ хийсэн өдөр хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Дахин үнэлж буй хөрөнгийн дансны үнийг бодит үнэ цэнээс материаллаг байдлаар зөрүүгүй байлгах давтамжтайгаар хөрөнгийн үнэлгээг хийнэ.

Газар ба барилгыг дахин үнэлэх давтамж нь үнэлж буй тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна. Үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнгээсээ материаллаг хэмжээгээр зөрж буй үед цаашдын дахин үнэлгээ шаардлагатай. Зарим газар ба барилгын бодит үнэ цэнэ нь их хэмжээгээр, хувьсан өөрчлөгддөг тул жил бүр үнэлэх шаардлагатай байдаг. Бодит үнэ цэнэ нь бага хэмжээгээр өөрчлөгддөг газар ба барилгынхувьд тогтмол үндсэн хөрөнгийн үнэлгээ шаардлагагүй. Үүний оронд гурав эсвэл таван жил тутам үнэлэх шаардлагатай.

Үндсэн хөрөнгө дахин үнэлснээс үүссэн нэмэгдлийг эздийн өмчийн тайлангийн үндсэн хөрөнгө дахин үнэлсний нэмэгдэл хэсэгт тайлагнана. Хэрэв үндсэн хөрөнгийг өмнө нь дахин үнэлээд дахин үнэлгээний бууралтыг орлого үр дүнгийн тайланд тусгасан байсан хөрөнгийг дахин үнэлснээр нэмэгдэл бүртгэхээр байвал өмнөх тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн зардлыг буцааж орлого үр дүнгийн тайланд тайлагнаж болно.

Мөн үүнтэй адил үндсэн хөрөнгийг өмнө нь дахин үнэлээд дахин үнэлгээний нэмэгдүүлгийг эздийн өмчийн хэсэгт тусгасан байсан бол тайлант хугацаан дах тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг эздийн өмчийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнтэй цэвэршүүлэх ба бусад тохиолдолд орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашгийн хүлээлт үгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг ба зохистой үед залруулж тохируулдаг.

(11) Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж ба лиценз орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж Банкнд орж ирэх нь магадлалтай болсон үед биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусд нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнесийн нэгдлийн үед олж эзэмшсэн биет бус хөрөнгийн өртөг нь олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнэ байна. Анх

хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийгүнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг.

Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна. Үүнд:

Компьютерийн програм хангамж(банкны үндсэн програм хангамж)	2-10жил
Програм хангамжийн лиценз	1-3 жил

(12) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ.

Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлоход тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгө дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолдбайх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гудвиллтэй холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн тайлант үеүдэд буцаахгүй. Банк нь тайлагнасан хугацааны туршид санхүүгийн бус хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг бүртгэх шаардлагагүй байсан.

(13) Санхүүгийн баталгаа

Бизнесийн хэвийн нөхцөлд Банк аккредитив, баталгаа, хүлээн зөвшөөрөлт гэх мэт санхүүгийн баталгааг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр “Бусад өр төлбөр”-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

(14) Ажиллагсдын тэтгэмж**(i) Богино хугацаат тэтгэмж**

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(15) Татвар**(i) Тайлант хугацааны орлогын албан татвар**

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь тайлагналын өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

(ii) Хойшлогдсон орлогын албан татвар

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлогдсон орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ▶ Хэрэв хойшлогдсон орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.

Хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Үл хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Борлуулахад бэлэн хөрөнгийн бодит үнэ цэнийн дахин хэмжилттэй холбоотой БДО-д тусгагдсан татвараас бусад хойшлогдсон татвар ба орлогын албан татвар нь орлогын тайланд орлогын албан татварын буцаан авалт эсвэл зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Энэ нь, дараагаар БДО-с орлогын тайлан руу холбогдох хойшлуулсан ашиг алдагдлын хамт дахин ангиллагдана. Мөн Банк нь, өөрийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой зардал, төлбөрийн татварын үр дагаварыг өөрийн хөрөнгө гэж шууд хүлээн зөвшөөрнө.

Банк нь хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй ба тооцоог цэвэр дүнгээр барагдуулах зорилготой бол цэвэршүүлэн тайлагнаж болно.

(16) Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилна. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гадны нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

(17) Бусад нөөцийн сан

Банкны санхүүгийн байдлын тайлан дээрх өөрийн хөрөнгөд бүртгэгдсэн бусад нөөцөд дараах нөөцүүд орно. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц

Банкны барилга болон газар дахин үнэлсэнээс үүссэн нэмэгдлийг бүртгэдэг нөөцийн сан.

Нөөцийн сан

Банк нь урьдчилан тооцоолоогүй эрсдэлээс хамгаалахын тулд тус санг байгуулсан. Банкны захирлуудын зөвлөлийн шийдвэр дээр үндэслэсэн хуримтлагдсан ашгийн хуваарилагдаагүй хэсгээс тус нөөцийн санд хуваарилдаг.

Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн сан

Банкны ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн бусад дэлгэрэнгүй орлого хэсэгт тайлагнасан “Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн сан”-д борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг оруулдаг.

Нийгмийн хөгжлийн сан

Банк нь өөрийн ажиллагсдыг эдийн засгийн хүндрэлтэй үед нь дэмжих зорилгоор хуримтлагдсан ашгаас Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг

3. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2016 мян. төг	2015 мян. төг
Бэлэн мөнгө болон Монголбанкн дахь хадгаламж	8,008,402	7,067,839
Урвуу репо хэлцэл	294,923	36,419
Бусад банкн дахь харилцах, хадгаламж	7,522,733	1,907,670
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	167,554,470	171,427,609
Санхүүгийн хөрөнгө оруулалт- борлуулахад бэлэн	22,669,827	20,759,040
Санхүүгийн хөрөнгө оруулалт- дуусгавар хугацаа хүртэл эзэмших	17,004,256	15,128,546
	223,054,611	216,327,123
Своп арилжаанаас олсон хүүний орлого	301,827	1,204,636
	223,356,438	217,531,759

Борлуулахад бэлэн болон дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтаас олсон хүү болон түүнтэй адилтгах орлогод засгийн газрын бондоос олсон 32,154,458мян.төгрөг багтсан. (2015 онд: 21,920,031 мян.төгрөг)

4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2016 мян. төг	2015 мян. төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж	26,475,983	18,365,306
Репо хэлцлүүд	1,074,953	689,176
Харилцагчдын харилцах, хадгаламж	117,614,602	116,335,105
Зээлээр авсан эх үүсвэр	9,581,534	7,583,028
	154,747,072	142,972,615
Своп арилжааны хүүний зардал	104,837	459,574
	154,851,909	143,432,189

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	2016 мян. төг	2015 мян. төг
Хураамж ба шимтгэлийн орлого		
Зээлийн шимтгэл, хураамж	5,140,222	5,086,693
Мөнгөн гуйвуулга болон бусад үйлчилгээний орлого	2,248,146	1,620,240
Картын үйлчилгээний шимтгэл, хураамж	4,576,166	4,242,145
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	7,742,553	6,955,087
Бусад шимтгэл, хураамж	3,370,738	300,612
	23,077,825	18,204,777
Хураамж ба шимтгэлийн зардал		
Банкны үйлчилгээний хураамж	991,129	717,042
Картын гүйлгээний хураамж	1,481,030	1,107,116
	2,472,159	1,824,158
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	20,605,666	16,380,619

6. АРИЛЖААНЫ ЦЭВЭР ОЛЗ

	2016 мян. Төг	2015 мян. төг
Хувьцаа	–	3,717
Гадаад валют	1,578,923	3,117,921
Өрийн үнэт цаас	685,307	45,164
	2,264,230	3,166,802

Хувьцааны орлогод өөрийн хөрөнгийн үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжааны үр дүн болон тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд орно. Гадаад валютын орлогод спот, форвард, своп болон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлцлээс бий болсон ашиг алдагдлууд орно. Өрийн бичгийн орлогод өрийн бичгийн үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжааны үр дүн, тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд болон холбогдох хүүний орлого, зардал орно.

7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

	2016 мян. төг	2015 мян. төг
Гадаад валютын арилжааны бус олз, цэвэр	7,305,558	1,651,242
Хураан авсан хөрөнгийн эрсдэлийн санг буцаасны олз (Тодруулга 16)	–	93,931
Бусад	624,264	301,445
	7,929,822	2,046,618

8. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН ЗАРДАЛ

	2016 мян. төг	2015 мян. төг
Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал/(буцаалт)		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 14)	15,157,986	9,742,030
Бусад хөрөнгө (Тодруулга 16)	(26,301)	631,683
	15,131,685	10,373,713

8. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН ЗАРДАЛ

	2016 мян. төг	2015 мян. төг
Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал/(буцаалт)		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 14)	15,157,986	9,742,030
Бусад хөрөнгө (Тодруулга 16)	(26,301)	631,683
	15,131,685	10,373,713

9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2016 мян. төг	2015 мян. төг
Цалин, хөлсба урамшуулал	40,847,170	41,116,550
Эрүүл мэнд нийгмийн даатгалын сан	4,532,721	4,289,660
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 17)	5,798,366	5,510,181
Үйл ажиллагааны түрээс	4,922,174	4,855,490
Даатгалын хураамж	92,843	97,057
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тодруулга 18)	1,086,826	870,620
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	62,414	148,062
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	1,915	–
Бусад үйл ажиллагааны зардал	15,556,208	14,185,054
	72,900,637	71,072,674

10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

2016 болон 2015 онуудын 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болсон орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүнд:

	2016 мян. төг	2015 мян. төг
Тайлант жилийн татвар:		
Тайлант жилийн үр дүнд ногдох орлогын албан Татвар	120,281	8,665
Хойшлогдсон татвар:		
Түр зөрүү үүссэнтэй холбоотой	15,418	–
Данснаас хассан хойшлогдсон татварын хөрөнгө (тодруулга 19)	544,035	279,944
	679,734	288,609

Банк нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 3 тэрбум төгрөг хүртэл ашгаас 10% -ийн, 3 тэрбумаас дээш төгрөгийн ашгаас 25% -ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүний орлогод татвар тооцохгүй. Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал нь татвар ногдох орлогоос хасагдах зардал болдог.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын (буцаан авалт)/зардалд 2016 болон 2015 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	2016 мян.төг	2015 мян.төг
Татварын өмнөх ашиг	11,271,925	14,247,222
25%-ийн орлогын албан татвар (2015 онд 25%)	2,817,981	3,561,805
Тусгай хувийн татвар ногдох орлогын нөлөө	(11,076)	(8,675)
Татвараас чөлөөлөгдөх орлого	(8,054,982)	(5,502,768)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	503,103	1,731,493
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийн хөдөлгөөний нөлөө	5,424,708	506,754
Тайлант жилийн татварын зардал	679,734	288,609

2016 оны 12-р сарын 31-ний байдлаарх татварын алдагдал нь 19,737,235 мянган төгрөг бөгөөд (2015 онд 1,574,075 мянган төгрөг) Банк нь дараагийн хоёр жилд татварын алдагдлыг шилжүүлэн ашиглаж болох хангалттай татвар ногдох ашиг олох нь тодорхойгүй байгаа тул хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй болно.

2016 онд үр ашигт орлогын албан татварын хувь хэмжээ (5.82%) байсан. (2015 онд 2.03%)

11. БЭЛЭН МӨНГӨ БА МОНГОЛБАНК ДАХЬ ХАРИЛЦАХ

	2016 мян.төг	2015 мян.төг
Бэлэн мөнгө	67,709,412	51,905,754
Монголбанк дахь харилцах	220,708,767	246,178,456
	288,418,179	298,084,210

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрийндундаж үлдэгдлийн12.0% -аас багагүй байдаг. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр149,429сая төгрөг (2015 онд126,866сая төгрөг) ба гадаад валютаар 24,604 сая төгрөг (2015 онд11,694сая төгрөг) байсан.

12. БУСАД БАНК БА САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ,ХАДГАЛАМЖ

	2016 мян.төг	2015 мян.төг
Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	43,631,902	11,361,354
Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	98,575,065	94,590,330
	142,206,967	105,951,684

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллага дахь дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах болон хадгаламжийн дансуудыг хэлнэ.

13. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД

Доорх хүснэгтэнд хөрөнгө, өр төлбөр болон нэрлэсэн үнийг үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнээр харууллаа. Нэрлэсэн үнэ нь нийт дүнгээрээ үүсмэл санхүүгийн хэрэгслийн суурь үнэт цаасны дүн байх бөгөөд суурь хүү эсвэл хүүний индексээс шалтгаалан үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэлгээнд өөрчлөлт орно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах боловч зах зээлийн эрсдэл эсвэл зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлэхгүй.

	Бодит үнэ цэнэ			Бодит үнэ цэнэ		
	Нэрлэсэн үнэ	Хөрөнгө	Өр төлбөр	Нэрлэсэн үнэ	Хөрөнгө	Өр төлбөр
	2016	2016	2016	2015	2015	2015
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Валютын форвард хэлцэл	–	–	–	86,515,595	319,772	6,152
Валютын своп хэлцэл	174,500	–	6,997	12,399,600	89,812	–
	174,500	–	6,997	98,915,195	409,584	6,152

Үүсмэл санхүүгийн хэрэгслийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсвэл огт шаардагдахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байдаг. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний бага хэмжээний өөрчлөлт нь ч банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хянадаг. (Тодруулга 29.4-г үзнэ үү).

14. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	2016	2015
	мян. төг	мян. төг
Бизнесийн зээл	331,688,628	169,915,081
Орон сууцны зээл	260,014,922	147,917,102
Хэрэглээний зээл	507,166,312	569,906,767
Хөдөө аж ахуйн зээл	44,285,779	38,357,236
Бусад	3,275,852	3,275,932
	1,146,431,493	929,372,118
Хуримтлагдсан хүүний авлага	16,219,415	14,213,031
Нийт зээл ба урьдчилгаа	1,162,650,908	943,585,149
Үнэ цэнийн бууралтын сан	(33,655,220)	(19,137,675)
Цэвэр зээл ба урьдчилгаа	1,128,995,688	924,447,474

Нийт дүнгээр нь бүртгэлээс хасаагүй шилжүүлсэн хөрөнгө

Банк нь 2012 оны 10 дугаар сард тогтмол хүүтэй барьцаат зээлүүдийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг 100% авах эрхийг Монголын ипотекийн корпорацид ("МИК") худалдсан ба зээлүүдийн гүйцэтгэлд үүрэг хүлээх нөхцөлтэй. Банк уг багцын бараг бүх эрсдэл, өгөөжийг өөртөө авч үлдсэн гэж тодорхойлсон ба тиймээс багцыг өөрийн бүртгэлээс хасаагүй болно. Банк уг гүйлгээг барьцаат зээллэг гэж бүртгэсэн ба хүлээн авсан мөнгийг санхүүгийн өр төлбөр гэж бүртгэсэн. 2016 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар шилжүүлсэн зээлийн багцын бүртгэлийн дүн нь 2,326 сая төгрөг (2015 онд 3,249 сая төгрөг), өр төлбөрийн дүн нь 2,326 сая төгрөг (2015 онд 3,249 сая төгрөг) тус тус байсан.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Нийт дүнгээр нь хүлээн зөвшөөрөөгүй шилжүүлсэн хөрөнгүүд

Банк нь 2016 оны 2 дугаар сарын 3-ны өдөр болон 2016 оны 4 дугаар сарын 20-ний өдөр тогтмол хүүтэй барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг авах 100% эрхийг МИК-ийн эзэмшлийн тусгай зориулалтын компаниудад худалдаж, оронд нь Ипотекийн Зээлээр Баталгаажсан Бондыг “ИЗББ”-ыг худалдан авсан. Банк нь санхүүгийн тайланд зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрсөн ба давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн. Шилжүүлсэн өдрөөрх зээлийн багцын дансны дүн нь 22,705сая төгрөгбайв. Санхүүгийн тайланд давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг 20,434сая төгрөг болон 2,270сая төгрөгөөр тус бүр тусгасан. 2016онд 20,434сая төгрөгийн давуу эрхтэй ИЗББ-г Монголбанкнаас авсан зээлийг төлөхөд зарцуулсан.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн тохируулгыг зээлийн анги тус бүрээр нь салган үзүүлбэл:

	Бизнесийн мян.төг	Хэрэглээ- ний мян.төг	Орон Сууцны мян.төг	Хөдөө аж ахуйн мян.төг	Нийт мян.төг
2016 оны 12 дугаар сарын 31					
2016 оны 1дүгээр сарын 1-ээр	16,365,594	1,339,427	1,394,932	37,722	19,137,675
Тайлант жилд байгуулсан	15,317,915	4,003,096	4,448,624	176,131	23,945,766
Эргэн төлөлтөөр буурсан	(4,808,517)	(3,437,543)	(409,105)	(132,615)	(8,787,780)
Данснаас хассан	(542,820)	(97,621)	–	–	(640,441)
2016 оны 12 дугаар сарын 31-ээр	26,332,172	1,807,359	5,434,451	81,238	33,655,220
Тусгай үнэ цэнийн бууралт	15,673,816	39,081	1,269,614	–	16,982,511
Бүлгийн үнэ цэнийн бууралт	10,658,356	1,768,278	4,164,837	81,238	16,672,709
	26,332,172	1,807,359	5,434,451	81,238	33,655,220
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан зээлийн тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дүн	55,612,022	184,063	2,870,523	–	58,666,608
2015 оны 12 дугаар сарын 31					
2015 оны 1дүгээр сарын 1-ээр	5,808,040	2,657,936	551,314	378,355	9,395,645
Тайлант жилд байгуулсан	14,326,323	3,921,799	1,104,890	458,348	19,811,360
Эргэн төлөлтөөр буурсан	(3,768,769)	(5,240,308)	(261,272)	(798,981)	(10,069,330)
2015 оны 12 дугаар сарын 31-ээр	16,365,594	1,339,427	1,394,932	37,722	19,137,675
Тусгай үнэ цэнийн бууралт	7,742,335	162,095	–	–	7,904,430
Бүлгийн үнэ цэнийн бууралт	8,623,259	1,177,332	1,394,932	37,722	11,233,245
	16,365,594	1,339,427	1,394,932	37,722	19,137,675
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан зээлийн тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дүн	25,086,943	184,063	–	–	25,271,006

Дангаараа үнэ цэнийн бууралтад орсон зээлийн Банкны эзэмшиж буй барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 66,997сая төгрөг (2015 онд 56,297сая төгрөг) байна. Эдгээр үнэлгээг удирдлагаас хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээлэлд үндэслэн гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 29.2 “Зээлийн барьцаа хөрөнгө ба сайжруулалтууд” хэсгээс үзнэ үү.

15. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2016 МЯН. ТӨГ	2015 МЯН. ТӨГ
Борлуулахад бэлэн:		
Өмчөөрх хөрөнгө оруулалт		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгө	6,374,165	6,075,494
орруулалт, бодит үнэ цэнээрээ		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хөрөнгө оруулалт, өртгөөрөө	11,205	5,326
	6,385,370	6,080,820
Тогтмол орлоготой хөрөнгө оруулалт		
Ипотекийн зээлээр баталгаажсан энгийн бонд ("ИЗББ"), бодит үнэ цэнээр	19,397,613	17,069,618
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бонд	26,852,994	337,532
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Засгийн газрын бонд	76,888,050	144,961,256
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын үнэт цаас	161,140,480	52,283,919
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас	53,949,013	–
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өрийн бичиг	83,005,771	–
	421,233,921	214,652,325
	427,619,291	220,733,145
Барьцаанд буй борлуулахад бэлэн:		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Засгийн газрын бонд*	7,760,816	–
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:		
Монголбанкны үнэт цаас	–	9,975,131
Өрийн бичиг	–	29,584,790
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Засгийн газрын бонд	–	19,640,914
	–	59,200,835

*Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Засгийн газрын бонд:

2016 оны 12-р сарын 31-ний байдлаар, тус бонд нь Банкны буцаан худалдан авах хэлцлийн барьцаагаар бүртгэлтэй байсан.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгө оруулалт гэдэг нь Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт юм.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хөрөнгө оруулалт нь хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компанид оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжгүй учир тэдгээрийг өртгөөр нь бүртгэдэг. Үнэлгээний техникүүдийг ашиглан хийсэн бодит үнэ цэнийн тооцооллууд хоорондоо их хэмжээгээр зөрнө гэсэн хүлээлттэй байна. Энэ хөрөнгө оруулалтын хувьд зах зээлийн үнэ тодорхойгүй ба Банк энэхүү хөрөнгө оруулалтыг ойрын хугацаанд борлуулах хандлагагүй байгаа.

Энгийн "ИЗББ" нь Монголын Ипотекийн Корпорациас гаргасан хүү тооцдог, урт хугацаат үнэт цаас юм. (Тодруулга 14-г үзнэ үү)

Монголбанкны үнэт цаас нь хямдруулсан үнээр гаргасан, богино хугацаатай хөрөнгө оруулалт. Засгийн газрын үнэт цаас нь богино хугацаатай, хямдруулсан эсвэл урамшуулалтай үнээр гаргасан үнэт цаас юм. Засгийн газрын бонд нь урт хугацаатай, хүү тооцдог, хямдруулсан эсвэл урамшуулалтай үнээр гаргасан үнэт цаас юм.

Өрийн бичиг нь Сангийн Яамнаас Засгийн газрын 282 дугаар шийдвэр болон Улсын Их Хурлын 07 дугаар шийдвэрийг үндэслэн гаргасан үнэт цааснууд болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. БУСАД ХӨРӨНГӨ

	2016 мян. төг	2015 мян. төг
Өрийн бичгийн авлага	7,302,836	7,302,836
Хангамжийн ба бусад бараа материал	1,806,976	1,681,455
Урьдчилж төлсөн зардал	973,328	922,641
Орлогын албан татварын авлага	159,336	355,007
Бусад авлага	3,847,604	3,687,118
	14,090,080	13,949,057
Хасах нь:		
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан	(1,311,521)	(1,239,112)
	12,778,559	12,709,945

	2016 мян. төг	2015 мян. төг
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан		
1-р сарын 1-нээр	1,239,112	830,957
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	–	631,683
Данснаас хассан	–	(245,605)
Эргэн төлөлтөөр буурсан(Тодруулга 8)	(26,301)	–
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	98,710	22,077
12-р сарын 31-нээр	1,311,521	1,239,112
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан		
1-р сарын 1-нээр	–	93,931
Буцаасан дүн (Тодруулга 7)	–	(93,931)
12-р сарын 31-нээр	–	–

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. БУСАД ХӨРӨНГӨ

	Газар ба барилга мян.төг	Компьютер, тоног төхөөрөмж мян.төг	Тавилга, эд хогшил мян.төг	Тээврийн хэрэгсэл мян.төг	Дуусаагүй барилга мян.төг	Нийт мян.төг
2016 оны 12 сарын 31						
Өртөг/дахин үнэлсэн						
2016 оны 1-р сарын 1-нээр	69,885,229	14,785,232	18,789,086	5,757,998	23,740	109,241,285
Нэмэгдсэн	630,041	872,298	547,140	22,880	3,460,996	5,533,355
Данснаас хассан	–	(283,851)	(134,826)	(38,000)	(4,943)	(461,620)
Дахин ангилсан	1,641,386	29,986	(124,673)	–	(1,546,699)	–
2016 оны 12-р сарын 31-нээр	72,156,656	15,403,665	19,076,727	5,742,878	1,933,094	114,313,020
Хуриимлагдсан элэгдэл						
2016 оны 1-р сарын 1-нээр	8,217,752	11,493,775	7,803,938	2,483,584	–	29,999,049
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	1,986,025	1,542,230	1,707,810	562,301	–	5,798,366
Данснаас хассан	–	(282,866)	(98,449)	(17,891)	–	(399,206)
Дахин ангилсан	18,954	66,470	(85,424)	–	–	–
2016 оны 12-р сарын 31-нээр	10,222,731	12,819,609	9,327,875	3,027,994	–	35,398,209
Дансны цэвэр дүн	61,933,925	2,584,056	9,748,852	2,714,884	1,933,094	78,914,811

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Газар ба барилга	Компьютер, тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Дуусаагүй барилга	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2015 оны 12 сарын 31						
Өртөг/дахин үнэлсэн						
2015 оны 1-р сарын 1-нээр	63,292,552	12,871,642	17,568,706	5,549,877	1,061,982	100,344,759
Нэмэгдсэн	–	2,609,163	1,664,500	245,625	6,281,612	10,800,900
Данснаас хассан	(85,802)	(668,564)	(486,833)	(13,680)	–	(1,254,879)
Худалдан борлуулсан	(625,671)	–	–	(23,824)	–	(649,495)
Дахин ангилсан	7,304,150	(27,009)	42,713	–	(7,319,854)	–
2015 оны 12-р сарын 31-нээр	69,885,229	14,785,232	18,789,086	5,757,998	23,740	109,241,285
Хуримтлагдсан элэгдэл						
2015 оны 1-р сарын 1-нээр	6,573,770	10,704,408	6,443,723	1,948,695	–	25,670,596
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	1,832,087	1,469,866	1,651,298	556,930	–	5,510,181
Нэмэгдсэн	–	15,903	13,641	–	–	29,544
Данснаас хассан	(85,802)	(663,168)	(347,437)	(10,410)	–	(1,106,817)
Худалдан борлуулсан	(92,824)	–	–	(11,631)	–	(104,455)
Дахин ангилсан	(9,479)	(33,234)	42,713	–	–	–
2015 оны 12-р сарын 31-нээр	8,217,752	11,493,775	7,803,938	2,483,584	–	29,999,049
Дансны цэвэр дүн	61,667,477	3,291,457	10,985,148	3,274,414	23,740	79,242,236

Газар ба барилгад зах зээлийн үнэлгээгээр бүртгэгдсэн барилга багцсан ба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эдгээр барилгуудыг өртгөөр нь бүртгэсэн байсан бол 51,387 сая төгрөг байх байсан (2015 онд 50,642 сая төгрөг).

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны хувьд 1,834 сая төгрөгийн (2015 онд 209 сая төгрөг) гэрээний үүргийн дагуу худалдан авах үндсэн хөрөнгө болон тоног төхөөрөмж байсан. (Тодруулга 28 -аас үзнэ үү).

18. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Программ хангамж мян.төг	Программ хангамжийн эрх мян.төг	Нийт мян.төг
2016 оны 12-р сарын 31			
Өртгөөр			
1-р сарын 1-нээр	3,682,947	1,668,492	5,351,439
Нэмэгдсэн	162,006	771,303	933,309
Данснаас хассан	(501,722)	(599,500)	(1,101,222)
Дахин ангилсан	(580,000)	580,000	–
12-р сарын 31-нээр	2,763,231	2,420,295	5,183,526
Хуримтлагдсан хорогдол			
1-р сарын 1-нээр	2,472,293	761,239	3,233,532
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	374,603	712,223	1,086,826
Данснаас хассан	(499,808)	(599,499)	(1,099,307)
Дахин ангилсан	(500,958)	500,958	–
12-р сарын 31-нээр	1,846,130	1,374,921	3,221,051
Дансны цэвэр дүн	917,101	1,045,374	1,962,475
2015 оны 12-р сарын 31			
Өртгөөр			
1-р сарын 1-нээр	3,621,085	610,882	4,231,967
Нэмэгдсэн	61,862	1,057,610	1,119,472
12-р сарын 31-нээр	3,682,947	1,668,492	5,351,439
Хуримтлагдсан хорогдол			
1-р сарын 1-нээр	2,010,120	352,792	2,362,912
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	462,173	408,447	870,620
12-р сарын 31-нээр	2,472,293	761,239	3,233,532
Дансны цэвэр дүн	1,210,654	907,253	2,117,907

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ - ЦЭВЭР

	2016 мян. төг	2015 мян. төг
Хойшлогдсон татварын хөрөнгө (өр төлбөр)		
1-р сарын 1-ний өдрөөр	47,849	776,939
Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгасан	(50,164)	(449,146)
Хойшлогдсон татварын өр төлбөрийн буцаалт	40,343	–
Биет бус хөрөнгийн элэгдлийн түр зөрүү (Тодруулга 10)	(55,852)	–
Орлого зардлаар хүлээн зөвшөөрөгдсөн (Тодруулга 10)	(544,035)	(279,944)
12-р сарын 31-ний өдрөөр	(561,859)	47,849

	Хойшлогдсон татварын өр төлбөр мян.төг	Хойшлогдсон татварын хөрөнгө мян.төг	Цэвэр хойшлогдсон хөрөнгө мян.төг
2016оны 12 сарын 31-ний өдрөөр			
Санхүүгийн хөрөнгө- борлуулахад бэлэн дахин үнэлгээ	(499,310)	–	(499,310)
Биет бус хөрөнгийн элэгдэлтэй холбоотой түр зөрүү	(62,549)	–	(62,549)
	(561,859)	–	(561,859)
2015оны 12 сарын 31-ний өдрөөр			
Санхүүгийн хөрөнгө-борлуулахад бэлэн дахин үнэлгээ	(449,146)	–	(449,146)
Биет бус хөрөнгийн элэгдэлтэй холбоотой түр зөрүү	(6,697)	–	(47,040)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээ	(40,343)	–	–
Зээл олголтын хойшлогдсон шимтгэлийн хураамж	–	308,253	308,253
Дараагийн жилд шилжүүлэн тооцох татварын алдагдал	–	235,782	235,782
	(496,186)	544,035	47,849

20. БУСАД БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2016 мян. төг	2015 мян. төг
Банк, санхүүгийн байгууллагын харилцах	34,331,608	60,636,437
Банк, санхүүгийн байгууллагын хадгаламж	92,807,790	123,805,262
	127,139,398	184,441,699

Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжид дотоодын болон гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас байршуулсан харилцах, хадгаламжийн дансууд орсон. 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар Банкинд байршуулсан дотоодын болон гадаадын нийт харилцах хадгаламжийн дансууд нь жилийн 2.9% -14.75% (2015 онд 2.9% -14.75%) -ийн хүүтэй, 4-өөс 176 (2015 онд 4-176 хоног) хүртэлх хоногийн хугацаатай байсан болно.

21. РЕПО ХЭЛЦЭЛ

Бизнесийн ердийн үйл ажиллагаанд банк нь үнэт цаас зээлж, зээлдүүлдэг ба буцаан худалдан авах (репо) хэлцэлээр худалдаж мөн буцаан худалдах хэлцэл ("урвуу репо")-ийн дор үнэт цаас худалдан авч болдог.

Зээлсэн үнэт цаас ба урвуу репо хэлцэлүүд

Дараах хүснэгт нь зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаан дахь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хуримтлуулсан хүүний хамт төлсөн мөнгийг нэгтгэн харуулсан ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ.

	2016 мян. төг	2015 мян. төг
Зээлсэн үнэт цаас ба урвуу репо хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа	2,998,768	—

Зээлдүүлсэн үнэт цаас ба репо хэлцэлүүд

Дараах хүснэгт нь зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаан дахь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хуримтлуулсан хүүний хамт хүлээн авсан мөнгөнөөс үүссэн өглөгийг нэгтгэн харуулсан ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ.

	2016 мян. төг	2015 мян. төг
Зээлдүүлсэн үнэт цаасны бэлэн мөнгөөрх барьцаа	7,722,342	—

22. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2016 мян. төг	2015 мян. төг
Засгийн газар		
- Харилцах данс	145,095,213	150,525,786
- Хугацаагүй хадгаламж	—	4
- Хугацаат хадгаламж	97,923,561	80,845,523
- Баталгааны эх үүсвэр	224,089	179,177
Хувийн сектор		
- Харилцах данс	83,513,783	64,596,261
- Хугацаагүй хадгаламж	86,801	126,878
- Хугацаат хадгаламж	45,422,423	57,381,553
- Баталгааны эх үүсвэр	4,555,718	7,065,595
Иргэд		
- Харилцах данс	73,127,726	64,011,119
- Хугацаагүй хадгаламж	174,755,609	137,242,858
- Хугацаат хадгаламж	726,913,079	587,505,630
- Баталгааны эх үүсвэр	86	16,042
	1,351,618,088	1,149,496,426

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ

	2016 МЯН. ТӨГ	2015 МЯН. ТӨГ
Бусад байгууллагаас авсан эх үүсвэр		
Монголбанк	113,309,814	54,975,403
Сангийн яам	75,266,658	79,410,544
Сангийн яам - Азийн хөгжлийн Банк	2,803,336	291,709
Хөгжлийн Банк	84,074,498	9,405,623
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	21,000,000	23,956,400
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	13,876,103	13,175,974
Сангийн яам / Японы олон улсын хамтын ажиллагааны Банк	17,258,894	8,201,056
Монголын ипотекийн корпораци	7,275,984	3,252,398
Өрийн бичиг	14,993,838	–
Бусад	2,000,000	–
Эх үүсвэрийн нийт дүн	351,859,125	192,669,107

Дээрх эх үүсвэрүүд ньбарьцаагүй болно.

Зээлийн гэрээнүүдийн ихэнх нь тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байхыг банкнаас шаарддаг ба тус нөхцөлүүдийг дараах төрлүүдэд ангилан үзүүлж болно:

- Өөрийн хөрөнгийн харьцаа (эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа)
- Санхүүгийн эрсдэлийн холбогдох харьцаа үзүүлэлтүүд (гадаад валютын эрсдэлийн харьцаа, нийт гадаад валютын нээлттэй позиц, нэгж гадаад валютын арилжааны эрсдэлийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа,)
- Зээлийн харьцаа (нэг зээлдэгч болон өөрийн хөрөнгийн харьцаа, холбоотой талын зээлийн харьцаа болон нийт томоохон нөлөөллийн харьцаа)
- Бусад харьцаа (эргэлтийн бус хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, чанаргүй зээл болон нийт зээлийн харьцаа гэх мэт)

Биелүүлсэн байх шаардлагатай харьцаа үзүүлэлтүүдийг хангаагүй тохиолдолд холбогдох зээлийн үүрэг биелэгдээгүйд тооцогдох буюу зээл нь нэхэмжилсэн үед төлөгдөх шаардлагатай болно. Тиймээс харьцаа үзүүлэлтүүдийн биелэлтэд Банк төлөвлөлт шинжилгээний хэлтсээрээ дамжуулан сар болгон хяналт тавин ажилладаг.

Санхүүгийн газар нь Банкны гүйцэтгэлийн тайланд үндэслэн биелүүлсэн байх шаардлагатай харьцаа үзүүлэлтүүдийг, гүйцэтгэлээрх үзүүлэлтүүдтэй харьцуулж үр дүнг нь Актив, пассивын удирдлагын хороонд тайлагнадаг.

2016 оны 12-р сарын 31 болон 2015 оны 12-р сарын 31-ний байдлаар Банк нь биелүүлэх шаардлагатай бүх харьцаануудыг хангасан.

24. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2016 МЯН. ТӨГ	2015 МЯН. ТӨГ
Өглөг ба хуримтлагдсан зардал	2,383,286	3,193,628
Клирингийн түр саатал	3,951,833	3,455,363
Бусад	855,739	169,275
	7,190,858	6,818,266

25. ЭНГИЙН ХУВЬЦАА, БУСАД НӨӨЦ БА НОГДОЛ АШИГ

Энгийн хувьцаа

	1 бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцааны тоо		Дүн	
	2016	2015	2016 мян. төг	2015 мян. төг
	12-р сарын 31-ний өдрөөр	113,000	113,000	113,000,000

Бусад нөөц

	Нийгмийн хөгжлийн сан	Нөөцийн сан	Борлуулахад бэлэн санхүүгий хэрэгсэл	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Нийт бусад нөөц
	мян. Төг	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг
2016 оны 12-р сарын 31					
1-р сарын 1-ний өдрөөр	956,832	693,669	4,042,314	11,009,228	16,702,043
Хорогдуулалт	–	–	–	(461,926)	(461,926)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт	–	–	451,477	–	451,477
2016 оны 12-р сарын 31	956,832	693,669	4,493,791	10,547,302	16,691,594
2015 оны 12-р сарын 31					
1-р сарын 1-ний өдрөөр	956,832	693,669	–	12,116,641	13,767,142
Хорогдуулалт	–	–	–	(1,107,413)	(1,107,413)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт	–	–	4,042,314	–	4,042,314
2015 оны 12-р сарын 31	956,832	693,669	4,042,314	11,009,228	16,702,043

Ногдол ашиг

2016 болон 2015 онуудад ноогдол ашиг хуваарилаагүй болно.

26. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

Монгол улсын Засгийн газар нь өөрийн хэрэгжүүлж буй “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд банкинд 65 тэрбум төгрөгийн зээлийн багцыг шилжүүлэх шийдвэрийг 2016 оны 2-р сарын 22нд гаргасан. Банкны хүлээж авсан 65 тэрбум төгрөгийн хүүгүй зээлийн багц нь 5 жилийн хугацаатай ба хугацааны эцэст нэгж үнэ нь нэг сая төгрөг бүхий Төрийн банкны 65,000 ширхэг хувьцаанд хөрвөх нөхцөлтэй байна. 2016 оны 6 сарын 24-нд Монгол банк нь энэхүү хоёрдогч өглөгийг өөрийн хөрөнгөөр бүртгэх зөвшөөрөл олгосон болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (НЭМЭЛТ ТОДРУУЛГА)

	2016 МЯН. ТӨГ	2015 МЯН. ТӨГ
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	288,418,179	298,084,210
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	142,206,967	105,951,684
Монголбанкны үнэт цаас	53,949,013	9,975,131
Засгийн газрын үнэт цаас	161,140,480	52,283,919
Засгийн газрын бонд	84,648,866	164,602,170
	730,363,505	630,897,114
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагааг үл санхүүжүүлэх, Монголбанкинд заавал байлгах нөөц (Тодруулга 11)	(174,033,407)	(138,559,868)
Хасах нь: Бусад банкинд байршуулсан, анхны дуусгавар хугацаа нь гурван сараас дээш хугацаа бүхий харилцах, хадгаламж	(71,167,845)	(1,155,275)
Хасах нь: Засгийн газрын анхны дуусгавар хугацаа нь гурван сараас дээш хугацаа бүхий үнэт цаас	(116,372,076)	(52,283,919)
Хасах нь: Засгийн газрын анхны дуусгавар хугацаа нь гурван сараас дээш хугацаа бүхий бонд	(84,648,866)	(164,602,170)
Нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	284,141,311	274,295,882

28. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг(Тодруулга 29.2 үзнэ үү).

Болзошгүй өр төлбөр

Баталгаа нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу тендерийн үйл ажиллагаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг. Эдгээр гүйлгээний улмаас материаллаг алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг.

Тайлант жилийн эцэст Банкинд дараах нэг томоохон шийдэгдээгүй шүүхийн нэхэмжлэл байсан.Хадгаламж Банк ХХК болон Жаст Групп ХХК-ийн хооронд байгуулсан гэх баталгааны гэрээний хүчин төгөлдөр эсэхтэй холбоотойгоор Э.Сүрэнгийн эсрэг эрүүгийн хэргийн нэхэмжлэлийг 2013.11.28-ны өдөр Төрийн Банк ХХК нь Улсын мөрдөн байцаах газарт гаргасан. Энэхүү нэхэмжлэлийг гаргахаас өмнө иргэний хэргийн шүүхээс “Актив, пассив хөрөнгө шилжүүлэх гэрээ”-ний 2.3-т зааснаар Хадгаламж Банк ХХК-ийн үүрэг Төрийн Банк ХХК-нд шилжсэн гэсэн үндэслэлээр Төрийн Банк ХХК-иас 32.85 сая ам.доллар буюу 51,597 сая төгрөгийг хүсэж Э. Сүрэнгийн нэхэмжлэлийг хангасан шийдвэрийг гаргасан.

Шүүхийн нэхэмжлэл

Гэсэн хэдий ч Төрийн Банк ХХК нь дараах хоёр үндэслэлээр нэхэмжлэлийг зөвшөөрөөгүй. Үүнд: 1) Монголбанкны шийдвэрээр Хадгаламж Банк ХХК-ийн зарим хөрөнгө, өр төлбөр, мөн түүнчлэн түүний салбаруудыг Төрийн Банк ХХК-нд шилжүүлсэн ба Төрийн Банк ХХК, Хадгаламж Банк ХХК-иудын хооронд байгуулсан “Хөрөнгө, өр төлбөр шилжүүлэх гэрээ”-ний дагуу Э. Сүрэнд төлөх багц өр төлбөрүүд нь Төрийн Банк ХХК-нд шилжиж ирээгүй, 2) гэрээнүүд, баталгааны хэрэгслүүд, Хадгаламж Банк ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэл зэрэг нотлох баримтууд нь Хадгаламж Банк ХХК-ийн Эрх хүлээн авагчийн архивт байхгүй байгаа тул хуурамч баримтууд байж болзошгүй ба эдгээр баримтуудын дугаар дээр өөр баримтууд байгаа.

Дээрх 2013 оны шүүхийн шийдвэрийг өмнөх байцаалтын үеэр мэдэгдээгүй байсан шинэ нотлох баримтанд үндэслэн Дүүргийн Анхан Шатны шүүх 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 472 дугаарт тушаалаар хүчингүй болгосон. Гэвч энэхүү 472 дугаарт тушаалыг 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр уг шүүх буцаасан байна.

2015 оны 1 дүгээр сарын 23-ний өдөр тухайн шүүхээр уг хэргийг дахин хэлэлцээд 2013 онд гарсан 1921 дүгээр шийдвэрийг хүчинтэйд тооцож 186 дугаар тогтоолыг гаргасан. 2015 оны 11 сарын 11-ний өдөр Хадгаламж банк нь уг баталгааг Актив Пассив шилжүүлэх гэрээний дагуу Хадгаламж Банкны эрх хүлээн авагчаас Төрийн Банкруу шилжүүлээгүй гэх үндэслэлээр шүүхэд гомдол гаргасныг Хадгаламж банкны эрх хүлээн авагч хүлээн зөвшөөрсөн байна. 2016 оны 2 дугаар сарын 3-ны өдөр Банкны удирдлага дээрх баталгаа нь Төрийн банкны хариуцахүүрэг бишгэдгийг батлах хангалттай нотлох баримт үүссэн гэсэн үндэслэлээр уг хэргийг дахин шүүхэд өгсөн байна. Шинээр үүсэн нөхцөл байдлын умлаас танилцуулсан нотлох баримтыг дахин хэлэлцэх шүүхийн үйл явц явагдсаар байна.

Дээр дурдсан үндэслэлээр Банкны удирдлага уг хэргийн эцсийн шийдвэр Банкны талд нааштай шийдэгдэнэ гэдэг итгэлтэй байгаа. Тиймээс 2016 болон 2015 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар Банк ямар нэг өр төлбөр бүртгээгүй болно.

Үйл ажиллагааны түрээсийн үүрэг – Түрээслэгч нь Банк

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслэгч болж төрөл бүрийн барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ нэг сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа шинэчлэх, худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банкинд эдгээр түрээсийн гэрээнд тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**29. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА****29.1 Оршил**

Банкны үйл ажиллагааны салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлүүд байдаг ба эдгээр эрсдэлүүдийг Эрсдэлийн Удирдлагын Хороо удирдаж байдаг. Эрсдэлийн Хороо нь Гүйцэтгэх Захиралд шууд тайлагнадаг бие даасан нэгж юм.

Эрсдэлийн Удирдлагын үндсэн зорилго нь бизнесийн сегментэд эрсдэл өгөөжийн түвшинтэй нь уялдуулан капиталыг зөв хуваарилах болон Банкны хөрөнгийн эрсдэл тохируулсан өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд байнгын илрүүлэлт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан эрсдэлийг удирдах явдал юм. Энэ үйл явц нь Банкны тасралтгүй ашигт ажиллагаанд маш чухал үүрэгтэй ба Банкны ажилтан бүрийн оролцоо, тэдний ажил үүргийн хариуцлагын хүрээнд эрсдэлийг илрүүлэхтэй шууд холбоотой юм.

Дээр дурьдсан эрсдэлийн удирдлагын явцад бизнесийн эрсдэлийн удирдлага багтаагүй болно. Бизнесийн эрсдэл гэдэг нь бизнесийн хүрээлэн буй орчин, технологи, болон үйл ажиллагаа явуулж буй салбарт гарсан өөрчлөлтүүдээс үүссэн эрсдэлийг хэлнэ. Эдгээр бизнесийн эрсдэлүүд нь Банкны стратеги төлөвлөлтийн хүрээнд хянагдаж байдаг.

Банк нь эрсдэлийг бүрмөсөн арилгахад чиглэхээс илүүтэйгээр эрсдэл, өгөөжийг хамгийн оновчтой хослуулахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын бодлоготой. Одоо мөрдөж буй эрсдэлийн удирдлагын систем нь дараах зарчмуудыг агуулсан байна. Үүнд::

- (i) Эрсдэлүүдийг удирдаж буй этгээд нь зохицуулалтын болон хэмжилтийн системийг сайн ойлгож байна;
- (ii) Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс (“ТУЗ”) баталсан хязгаарын хүрээнд эрсдэлийг илрүүлж байна;
- (iii) ТУЗ-өөс баталсан бизнесийн бодлогын дагуу эрсдэлийг хэмжиж байна;
- (iv) Капиталын хуваарилалт нь эрсдэлийн түвшинтэйгээ уялдаж байна;
- (v) Банкны гүйцэтгэлийн зорилт нь эрсдэл даах байдалтай уялдаж байна.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Банкны удирдлагын бүх түвшинд эрсдэлийн талаарх нэгдсэн ойлголттой байж дараах шатны хороод эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо (“ЭУАЭХ”)

ТУЗ нь банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжүүлж ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын Хороо (“ЭУХ”)

Эрсдэлийн Удирдлагын хороо нь Банкны бизнес нэгжүүдийн болон үйл банкны үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, мөн үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон бусад эрсдэлүүдийг багасгах зорилгоор тэдгээрийг үнэлэх, мөн банкны хяналт, эрсдэлийн удирдлагын бодлогод шаардлагатай сайжруулалтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгч ажилладаг. Банкны хувьд төв ЭХ болон салбарын ЭХ гэсэн хоёр түвшний эрсдэлийн хороо үйл ажиллагаагаа явуулж байна.

Дотоод аудит

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэг удаа аудит хийх ба аудитын үед банкны журмуудын зохистой байдал хийгээд Банк эдгээр журмуудыг хэр мөрдөж байгаад хяналт хийдэг. Дотоод аудитын газар нь хийсэн бүх үнэлгээнийхээ үр дүнг банкны удирдлагатай хэлэлцэж, илрүүлсэн алдаа, дутагдал болоод өгөх зөвлөмжүүдийн талаар ТУЗ болон ЭУАЭХ-нд тайлагнана.

Актив Пассивын Удирдлагын Хороо (“АПУХ”)

АПУХ нь зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үндсэн нэгж юм. Банкны эрсдэлийн удирдлагын стратегийг боловсруулж, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх ЭУАЭХ-нд санал оруулах, батлуулах, эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, холбогдох хязгаарлалтуудыг тогтоож мөрдүүлж ажиллуулах үүрэгтэй.

Зээлийн Хороод

Зээлийн хороод нь дотоод журмаар тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд зээлийн шийдвэр гаргадаг. Зээлийн хороод нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд :

- зээлийн багц дахь чанар, бүтэц болон эрсдэлтэй багцыг тогтмол хянах;
- салбар тус бүрээр болон газарзүйн бүсийн байршлын хувьд олгогдох зээлийн хэмжээг тогтоон батлах;
- зээлийн бодлого, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, батлах;
- зээлийн ангилал болон сан байгуулах түвшин хэмжээг батлах;
- зээлийн хүсэлт/өргөдөл батлах.

Эрсдэлийн Удирдлагын Газар

Эрсдэлийн удирдлагын газар банкны хэмжээнд эрсдэлийн бодлогын хэрэгжилтийг хянаж, эрсдэлийн төрөл бүрээр эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрсдэлийг оновчтой удирдахад шаардлагатай мэдээллээр удирдлагыг хангаж, тухай бүр санал дүгнэлт гаргаж холбогдох хороодоор шийдвэрлүүлж ажилладаг. ЭУГ нь өөрийн гурван хэлтсээр дамжуулан эрсдэлийн бодлого, холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавина.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь үйл ажиллагаа, зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлох, холбогдох арга аргачлалыг тогтоож боловсронгуй болгох, эрсдэлийг хохирол багатай даван туулах талаар удирдлагад санал зөвлөмж хүргүүлэх, тэднийг эрсдэлийн түвшин, үр нөлөөллийн талаархи мэдээллээр ханган ажилладаг.

Тусгай активын хэлтэс

Тусгай активын хэлтэс нь чанаргүй актив үүсэхээс сэргийлэх, активын чанарыг сайжруулах чиглэлд бусад газар, хэлтэс, нэгжүүдтэй хамтран ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, чанаргүй активыг шилжүүлэн авч барагдуулах, хохирлыг бууруулах ажлыг зохион байгуулдаг.

Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс:

Зээлийн эрсдэлийн удирдлагыг хэлтэс дараах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- (i) Зээлийн эрсдэлийн үнэлгээ, судалгааг хийх;
- (ii) Зээлийн эрсдэлийн түвшинг тогтоохын тулд зээлийн өргөдөлд бие даасан эрсдэлийн үнэлгээг хийх;
- (iii) Зээлийн багцыг хянах болон зээлийн багцын эрсдэлийг салбар тус бүрээр болон газарзүйн бүсийн байршлын хувьд хэт төвлөрүүлэхгүй байх;
- (iv) Олон төрлийн аргачлал ашиглан Банкны зээлийн багцын эрсдэлийг бууруулах.

Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдэлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг.

Эрсдэлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдэлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдэлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьж байдаг.

Эрсдэлийг цаг алдалгүй олж таних, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилж үздэг. Ингэж боловсруулсан мэдээллийг ТУЗ, ЭУАЭХ, Актив пассивын удирдлагын хороо, ЭХ, зээлийн хороод болон бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлбарладаг. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, кредит метрикийн таамаглал, тогтоосон лимитийн гажилт, VaR, хөрвөх чадварын харьцаа болон эрсдэлийн утгуудын өөрчлөлтийг тусгана.

Улирал бүр Актив пассивын удирдлагын хороо болон Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд бүх шаардлагатай мэдээллээр хангах зорилготой иж бүрэн эрсдэлийн тайланг хүлээн авдаг. Долоо хоног бүр Актив пассивын удирдлагын хороонд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдэлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Эрсдэлийг бууруулах

Хүүний түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ болон VaR аргаар тооцон, хянаж ажилладаг.

Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө болон хувь хүний батлан даалт авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Төвлөрөл нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн ойролцоо шинж чанартай бизнес эрхэлдэг хэд хэдэн харилцагчид улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал үүсдэг. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Зээлийн эрсдэлд тодорхойлогдсон төвлөрлийг хянаж удирдана. Монголбанк /Төв банк/ дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- (i) Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй.
- (ii) Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтрэхгүй.

Банкны журмын дагуу хадгаламжийн төвлөрлийн түвшинд тохирох хангалттай хөрвөх чадварыг Банк нь барих ёстой.

29.2 Зээлийн эрсдэл

Банкны харилцагч, үйлчлүүлэгч, зээлдэгч, зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох эсвэл төлөхийг хүсэхгүй байх, зээлийн гэрээний болон бусад санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлд Банк өртдөг. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүгийн хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг газарзүйн байршил, аж үйлдвэрийн салбараар ангилан зээлийн эрсдэлд өртөх түвшинд хязгаар тогтоох зэргээр зээлийн эрсдэлд хяналт тавьдаг.

Банк нь харилцагч талуудын зээлжих чадварт орж болзошгүй өөрчлөлт (барьцаа хөрөнгөө тогтмол шинэчлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессийг нэвтрүүлсэн. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банкинд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээнүүдийг эртхэн авах боломжийг олгодог.

Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг ойр ойрхон шалгаж сайжруулдаг байдаг.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаануудыг гаргах боломжийг бий болгодог. Ийм төлбөрийг аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулдаг.

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл:

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдэлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	Нийт багцын хэмжээ 2016 мян.төг	Нийт багцын хэмжээ 2015 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (касс дахь бэлэн мөнгийг оролцуулаагүй)	220,708,767	246,178,456
Бусад банкин дахь харилцах, хадгаламж	142,206,967	105,951,684
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,998,768	–
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	–	409,584
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа	1,162,650,908	943,585,149
Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн	421,233,921	214,652,325
Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл	–	59,200,835
Барьцаанд байгаа санхүүгийн хөрөнгө оруулалт– эзэмших борлуулахад бэлэн	7,760,816	–
Бусад хөрөнгө	11,150,440	10,989,954
Нийт	1,968,710,587	1,580,967,987
Болзошгүй өр төлбөр	1,068,215	2,374,640
Үүргүүд	1,495,988	4,038,655
Нийт	2,564,203	6,413,295
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн	1,971,274,790	1,587,381,282

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэгсэл хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан ба энэ нь ирээдүйд үнэ цэнэ өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш юм.

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг (Тодруулга 14) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, нийт дүнгээр (зээлийн барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нь) үзүүлэв.

	2016 Нийт багцын хэмжээ		2015 Нийт багцын хэмжээ	
	мян.төг	%	мян.төг	%
Хэрэглээний	778,887,672	67%	772,023,364	82%
Хөдөө аж ахуй	167,511,609	14%	53,048,627	6%
Барилга	61,859,503	5%	45,105,745	5%
Үйлдвэр	48,588,023	4%	27,585,685	3%
Боловсрол	3,222,678	0%	8,911,937	1%
Бөөний болон жижиглэн	29,934,133	3%	8,022,555	1%
Үл хөдлөх хөрөнгө	6,633,455	1%	6,265,972	1%
Аялал жуулчлал	2,541,432	0%	3,359,570	0%
Цахилгаан ба газрын тос	1,610,723	0%	3,162,555	0%
Эрүүл мэнд хамгаалал	2,851,597	0%	2,892,716	0%
Тээвэр, харилцаа холбоо	5,370,335	0%	2,891,320	0%
Санхүүгийн үйлчилгээ	2,789,452	0%	2,219,571	0%
Бусад	44,816,017	4%	5,214,787	1%
Уул уурхай, олборлолт	5,995,018	1%	1,671,719	0%
Нийтийн үйлчилгээ	39,261	0%	1,182,148	0%
Нийгмийн үйлчилгээ	–	0%	26,878	0%
	1,162,650,908	100%	943,585,149	100%

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд**

Шаардлагатай барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ ба олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- (i) Байгууллагуудад олгосон зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- (ii) Жижиг бизнесийн зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал
- (iii) Хэрэглээний зээлийн хувьд автомашин, санхүүжилтийн орлого, болон үл хөдлөх хөрөнгө, гэх мэт;
- (iv) Орон сууц худалдан авах зээлийн хувьд орон сууц;

Банк нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид зээл олгохдоо тухайн компаний толгой компани болон гол хувьцаа эзэмшигчдээс баталгаа гаргуулж авч болох боловч барьцаа хөрөнгөөр тооцдоггүй.

Банк нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянаж байдаг ба тухайн гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахаар хүсэлт тавьдаг.

Банкны журмаар өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг Банк нь зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгө борлуулсанаас орж ирсэн орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах эсвэл төлж дуусгахад зориулна. Банк нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Санхүүгийн хөрөнгийн бүлэг нэг бүрийн чанар

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны чанарыг Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний системийг ашиглан удирддаг.

Банкны зээлийн эрсдэлийн үнэлгээний системийг дараах хүснэгтээр үзүүлэв:

Зээлийн зэрэглэл	Тодорхойлолт
A	Маш сайн
B	Сайн
C	Хангалттай
D	Хэвийн бус

Банк зээлийн багцдаа зохистой, байнгын эрсдэлийн зэрэглэл тогтоож байх бодлогыг баримталдаг. Энэ нь зарим төрлийн эрсдэлийг удирдах боломжийг олгохын зэрэгцээ, бүх зээлүүдийн эрсдэлийг нэг хэмжигдэхүүнээр илэрхийлэн харуулах боломжийг олгодог. Үнэлгээний систем нь харилцагчийн зээлийн эрсдэлд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн статистик шинжилгээ болон зах зээлийн мэдээлэлд суурилагдан хийгддэг. Эрсдэлийн зэрэглэл нь төрөл бүрийн зээлийн эрсдэлтэй уялдсан бөгөөд зээл эрсдэх тохиолдолд алдагдлыг бууруулах барьцаа хөрөнгө, эсхүл бусад төрлийн алдагдлыг бууруулах зээл тус бүр ялгаатай байна гэсэн бодлогыг баримталдаг.

Зээлийн багцын чанар, эрсдэлийн ангиллаар

Дараах хүснэгтэд зээлийн чанарыг Банкны зээлийн дотоод үнэлгээний систем дээр үндэслэн зээлтэй холбоотой хөрөнгийг бүлэг тус бүрээр нь үзүүлэв. Үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй дүнгээр үзүүлэв

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Зээлийн багцын чанар, эрсдэлийн ангиллаар

Дараах хүснэгтэд зээлийн чанарыг Банкны зээлийн дотоод үнэлгээний систем дээр үндэслэн зээлтэй холбоотой хөрөнгийг бүлэг тус бүрээр нь үзүүлэв. Үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй дүнгээр үзүүлэв

Тодруулга	2016						
	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл				Хугацаа хэтрэсэн эсвэл		
	Маш сайн мян. төг	Сайн мян. төг	Хангалттай мян. төг	Хэвийн бус мян. төг	Үнэлээгүй мян. төг	дангаараа үнэ цэнийн бууралттай мян. төг	Нийт мян. төг
Бэлэн мөнгө ба Монголбанк дах харилцах	11	220,708,767	-	-	-	-	220,708,767
Бусад банкин дахь харилцах, хадгаламж	12	40,778,921	1,587,736	99,840,310	-	-	142,206,967
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	21	-	-	2,998,768	-	-	2,998,768
Санхүүгийн хөрөнгө оруулалтууд	15	401,836,308	-	-	-	19,397,613	421,233,921
Борлуулахад бэлэн		7,760,816	-	-	-	-	7,760,816
Барьцаанд байгаа борлуулахад бэлэн		409,597,124	-	-	-	19,397,613	428,994,737
14		263,869,305	4,730,283	99,641	140,026	-	336,592,834
Зээл ба урьдчилгаа		506,986,067	2,108,677	151,811	781,249	-	515,850,656
Бизнесийн зээл		254,287,973	2,284,416	6,568	231,067	-	261,123,784
Хэрэглээний зээл		45,264,153	62,045	1,021	-	-	45,807,782
Орон сууц худалдан авах зээл		-	3,275,852	-	-	-	3,275,852
Хөдөө аж ахуйн зээл		1,070,407,498	12,461,273	259,041	1,152,342	-	1,162,650,908
Бусад		1,228,402	-	-	-	-	1,228,402
16		1,742,720,712	14,049,009	103,098,119	1,152,342	19,397,613	1,968,710,587
Бусад хөрөнгө		-	-	-	-	9,922,038	9,922,038
Нийт		1,742,720,712	14,049,009	103,098,119	1,152,342	88,292,792	1,968,710,587

ТӨРИЙН БАНК ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		2015					
		Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл			Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай		
Тодруулга	Маш сайн	Сайн	Хангалттай	Хэвийн бус	Үнэлээгүй	мян. төг	Нийт
	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг
Бэлэн мөнгө, богинохугацаат сангууд	246,178,456	-	-	-	-	-	246,178,456
Бусад банкин дахь харилцах хадгаламж	10,444,685	1,811,138	-	93,695,861	-	-	105,951,684
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	409,584	-	-	-	-	-	409,584
15 Санхүүгийн хөрөнгө оруулалтууд							
Борлуулахад бэлэн	197,582,707	-	-	-	17,069,618	-	214,652,325
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаас	59,200,835	-	-	-	-	-	59,200,835
	256,783,542	-	-	-	17,069,618	-	273,853,160
14 Зээл ба урьдчилгаа							
Бизнесийн зээл	131,757,421	10,730,666	195,100	65,528	-	29,022,067	171,770,782
Хэрэглээний зээл	541,458,056	2,196,319	218,309	747,050	-	3,486,650	548,106,384
Орон сууц худалдан авах зээл	177,791,440	1,505,787	196,322	127,480	-	529,105	180,150,134
Хөдөө аж ахуйн зээл	39,107,392	729,921	5,799	-	-	438,805	40,281,917
Бусад	-	3,275,932	-	-	-	-	3,275,932
	890,114,309	18,438,625	615,530	940,058	-	33,476,627	943,585,149
16 Бусад хөрөнгө	3,605,918	-	-	-	-	7,384,036	10,989,954
Нийт	1,407,536,494	20,249,763	615,530	94,635,919	17,069,618	40,860,663	1,580,967,987

Харилцагчдад олгосон хугацаа хэтэрсэн зээл болон урьдчилгаанд зөвхөн цөөн хэдэн хоногоор хугацаа хэтэрсэн зээлүүд орсон. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн насжилтын шинжилгээг дор үзүүлэв.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээ

2016.12.31-ний өдрөөр	30 хоног хүртэл мян. төг	31-60 хоног мян. төг	61-90 хоног мян. төг	91-ээс дээш хоног мян. төг	Нийт мян. төг
Бизнесийн зээл	1,558,710	6,052,171	1,470,621	2,707,085	11,788,587
Орон сууц худалдан авах зээл	122,986	35,971	300,470	1,318,538	1,777,965
Хэрэглээний зээл	552,279	587,246	449,055	4,067,929	5,656,509
Хөдөө аж ахуйн зээл	6,898	9,021	34,459	430,707	481,085
Нийт	2,240,873	6,684,409	2,254,605	8,524,259	19,704,146

2015.12.31-ний өдрөөр	30 хоног хүртэл мян. төг	31-60 хоног мян. төг	61-90 хоног мян. төг	91-ээс дээш хоног мян. төг	Нийт мян. төг
Бизнесийн зээл	815,618	269,556	879,032	1,970,918	3,935,124
Орон сууц худалдан авах зээл	50,930	27,750	113,577	336,848	529,105
Хэрэглээний зээл	283,092	334,751	159,597	2,525,147	3,302,587
Хөдөө аж ахуйн зээл	32,405	37,372	7,869	361,159	438,805
Нийт	1,182,045	669,429	1,160,075	5,194,072	8,205,621

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй зээл, урьдчилгааны нийт дүнд Банк нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 28,297 сая төгрөг (2015 онд 6,745 сая төгрөг)-ийн үнэ бүхий хөрөнгийг барьцаалаад байна. Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаанд байгуулсан зээлийн алдагдлын сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 14-аас харна уу.

Нөхцөл өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн бүлэг тус бүрийн бүртгэлийн дүн

Нөхцөл өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн бүлэг тус бүрийн бүртгэлийн дүн

	2016 мян. төг	2015 мян. төг
Зээл ба урьдчилгаа:		
Бизнесийн зээл	33,130,483	14,213,272
Орон сууц худалдан авах зээл	5,304,785	20,588
Хэрэглээний зээл	367,922	334,458
Хөдөө аж ахуйн зээл	539,339	914,153
Төслийн зээл	21,157,628	12,994,423
Тусгай нөхцөлт зээл	5,483,601	239,157
	65,983,758	28,716,051

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Зээлийн үндсэн ба хүүний графикт төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн, зээлдэгчийн мөнгөн урсгалд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлийн үнэлгээ буурсан, зээлийн гэрээний анхны нөхцөл зөрчигдсөн эсэх зэрэг асуудлуудыг зээлийн үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг. Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг бүлгийн ба тусгайлсан үнэлгээ гэж ялган авч үздэг.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**Тусгайлсан үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын сан**

Банк нь өндөр дүнтэй зээл, урьдчилгаанд нэг бүрчлэн зээлийн эрсдэлийн тохирох санг тооцдог. Зээлийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, санхүүгийн хүндрэл тохиолдсон үед гүйцэтгэлээ сайжруулах чадвар, дампуурал тохиолдсон үед хүлээн авах төлбөр болон хүлээгдэж буй ногдол ашгийн төлбөр, санхүүгийн өөр бусад дэмжлэг авах боломжууд, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа зэргийг зайлшгүй авч үздэг. Үнэ цэнийн бууралтаас үүсэх алдагдлын хэмжээг, гэнэтийн үйл явдлуудын улмаас илүү нухацтай авч үзэх шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд тайлант өдөр бүр үнэлж үзнэ.

Бүлгийн үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын сан

Дангаараа чухал ач холбогдолгүй бүх зээл, урьдчилгаа ба дангаараа чухал ач холбогдолтой боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо гарч ирээгүй зээл, урьдчилгаануудыг бүлэглэн, бүлэг тус бүр дээр хүлээж болзошгүй алдагдлыг тооцно. Удирдлагын зүгээс бүлгийн үнэлгээг жил бүр, бүлэг тус бүрт ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг багтаасан багцын түвшинд оршин байх магадлалтай үнэ цэнийн бууралтыг тооцдог. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүлгийн алдагдлын түүхэн өгөгдөл, эдийн засгийн өнөөгийн байдал, алдагдал гарсан гэж таамаглаж буй үе болон уг алдагдлыг олж тогтоосон үе хоорондын ойролцоолсон хугацаа мөн үнэ цэнийн бууралттай гэж тогтоогдсоны дараа хүлээгдэж буй эргэн төлөгдөх эсвэл цуглуулан авах дүн зэрэг мэдээлэл дээр үндэслэн тогтоодог.

Санхүүгийн баталгаа болон аккредитивийг зээл ба урьдчилгаатай адил байдлаар үнэлж, сан байгуулдаг.

29.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон тогтворгүй нөхцөл байдалд харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэж чадахгүй байвал банк төлбөрийн чадварын эрсдэлд орно. Уг эрсдэлийг хязгаарлахын тулд удирдлага нь өөрийн үндсэн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс гадна олон төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн ба өдөр тутам ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн чадвараа хянаж байдаг.

Банк нь хангалттай хэмжээний, Монголбанкнаас шаарддаг түвшнээс илүү хэмжээ бүхий хөрвөх хөрөнгөтэй байдаг. Үүнээс гадна Банк нь нийт харилцагчдын харилцах, хадгаламжийн 12%-тай тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Дараах хүснэгтэд 2016 оны болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харууллаа. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлтэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдөл дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

2016 оны 12 сарын 31-нээр	Хугацаагүй мян.төг	3 сараас		3-6 сар мян.төг	6 сараас		1-5		5-аас дээш		Нийт дүн мян.төг
		Доош мян.төг	мян.төг		1 жил мян.төг	жил мян.төг	мян.төг	мян.төг			
Бусад банкны харилцах, хадгаламж	28,796,300	12,074,190	66,243,489	25,756,823	-	-	-	-	-	132,870,802	
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	174,500	-	-	-	-	-	-	-	174,500	
Харилцагчдын харилцах, хадгаламж	488,227,058	288,037,041	247,447,263	234,044,863	69,412,319	82,784,080	1,409,952,624				
Зээлээр авсан эх үүсвэр	18,301,325	63,621,833	1,702,723	63,872,068	107,647,218	168,317,463	423,462,630				
Репо хэлцэл	-	-	-	-	7,728,684	-	7,728,684				
Бусад өр төлбөр	7,190,858	-	-	-	-	-	7,190,858				
Нийт	542,515,541	363,907,564	315,393,475	323,673,754	184,788,221	251,101,543	1,981,380,098				
2015 оны 12 сарын 31-нээр											
Бусад банкны харилцах, хадгаламж	60,986,437	123,806,314	3,643,701	-	-	-	188,436,452				
Репо хэлцэл	-	138,739,908	-	-	-	-	138,739,908				
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	52,761	-	-	-	-	52,761				
Харилцагчдын харилцах, хадгаламж	423,765,212	285,339,894	175,116,573	232,206,720	85,587,222	99,448,150	1,301,463,771				
Зээлээр авсан эх үүсвэр	1,557,402	3,248,603	525,790	49,448,238	58,739,158	122,288,999	235,808,190				
Бусад өр төлбөр	6,818,266	-	-	-	-	-	6,818,266				
Нийт	493,127,317	551,187,480	179,286,064	281,654,958	144,326,380	221,737,149	1,871,319,348				

29.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүүний түвшин, гадаад валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Банк нь эрсдэлийн энэ элементийг VaR болон мэдрэмжийн шинжилгээг ашиглан хянаж удирддаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд ноцтой, зах зээлийн эрсдэлийн төвлөрөл байхгүй байна. Арилжааны багцын зах зээлийн эрсдэлийг эрсдэлийн хувьсагчдын харилцан хамааралыг илэрхийлэх VaR аргачлалыг ашиглан хянаж удирддаг. Арилжааны бус нөхцөл байдлыг бусад мэдрэмжийн шинжилгээг ашиглан хянаж удирддаг.

Хүүний түвшний эрсдэл

Тодорхой хугацааны заагуудад хүүний түвшинг тохируулж өгч байх шаардлагатай позицууд хоорондоо таарамжгүй болох үед хүүний эрсдэл бий болдог. Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүний эрсдэлийг бий болгодог. Хүүний хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүний цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг (Банкны хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлсийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлөх учраас). Тодорхой хугацаанд байж болох хүүний хувь хэмжээний өөрчлөлтийн хязгаарыг Банкны удирдлага

тогтоож өгдөг. Позицуудыг өдөр бүр хянаж байдаг ба хеджинг стратеги хэрэгжүүлэх замаар позицийг хязгаарын хүрээнд удирдаж ажилладаг.

Дараах хүснэгтэд Банкны орлогын тайлангийн зүйлүүдийн, бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүний хувь хэмжээний зохистой, боломжит өөрчлөлтүүдэд үзүүлэх мэдрэмжийг харуулав. Орлогын тайлангийн мэдрэмж гэж нэг жилийн хүүний цэвэр орлогод хүүний өөрчлөлт (2016 оны 12 дугаар сарын 31 ба 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хөвөгч хүүний өөрчлөлт)-ийн үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Валют	Өсөлт/ (Бууралт)	Цэвэр хүүний орлогын мэдрэмж	
		2016 мян.төг	2015 мян.төг
Евро	+/-120	14,005	10,489
Америк доллар	+/-120	708,394	312,175
Төгрөг	+/-120	668,208	2,283,874

Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн сөрөг өөрчлөлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Банкны удирдлага гадаад валютын позицууд дээр хязгаар тогтоож өгдөг ба тэдгээрийг тогтмол хянадаг. Үүнээс гадна Банк нь гадаад валютын эрсдэлийг удирдах, хэмжих үйл ажиллагаандаа VaR загварыг 2011 оны 6 дугаар сараас хэрэглэж эхэлсэн. VaR нь тодорхой хугацаанд ба өгөгдсөн итгэлцлийн түвшинд багцын зах зээлийн үнэд гарч болох өөрчлөлтийг ойролцоолон тооцоолох замаар санхүүгийн эрсдэлийг хэмжихэд ашиглагддаг арга юм.

'VaR аргачлалын зорилго, төсөөлөл, хязгаарлалтууд

VaR загвар нь зах зээлийн хэвийн орчинд зах зээлийн эрсдэлийг хэмжихэд ашигладаг. Эдгээр загварууд нь зах зээлийн хэвийн орчинд нөлөө үзүүлж буй эрсдэлийн хүчин зүйлүүд дээр гарч буй аливаа өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж авч үздэг. Банк нь өнгөрсөн нэг өдрийн түүхэн өгөгдөлд суурилан валютын багцад гарч болох өөрчлөлтүүдийг тооцоолохдоо түүхэн болон Монте Карло гэх хоёр загварыг ашигладаг. Банкны хэрэглэж буй VaR аргачлал нь 99 хувийн итгэлцлийн түвшин ба хэрэв одоогийн зах зээлийн эрсдэлийн хэмжээ нэг өдөр өөрчлөгдөхгүй хэвээр байхад болзошгүй алдагдлын хэмжээ нь хэтэрч илүү гарахгүй байх 1 өдрийн хугацааг ашигладаг ба эдгээр хувьсагчуудыг зах зээлийн өгөгдлийн 250 өдрийн хөдөлгөөнийг ажигласны үндсэн дээр тодорхойлдог. 99%-ийн итгэлцлийн түвшинг ашиглана гэдэг нь VaR-ын дүнгээс илүү гарсан алдагдалтай өдөр 100 өдөр тутамд нэгээс илүү тохиолдохгүй гэсэн үг.

VaR нь зах зээлийн үнэ ба үнийн ирээдүйн хөдөлгөөн нь статистик тархалттай байна гэж үздэг, мөн зах зээлийн үнийн түүхэн корреляц ба огцом өөрчлөлтүүд дээр суурилдаг учраас энэ аргыг хэрэглэхэд зарим нэг хязгаарлалтууд байдаг. VaR арга нь мэдээллийг гаргахдаа түүхэн өгөгдлүүд дээр их тулгуурладаг, эрсдэлийн хүчин зүйлүүдийн ирээдүйн өөрчлөлт ба хөдөлгөөнийг тодорхой харуулж чаддаггүй зэргийн улмаас хэрэв эрсдэлийн хүчин зүйлүүдийн өөрчлөлт нь хэвийн тархалттай байна гэсэн төсөөллөөс зөрвөл, зах зээлийн том хөдөлгөөнийг магадлалыг дутуу үнэлж болно. Эрсдэлийн хүчин зүйлүүд ба тодорхой нэг хэрэгслүүдийн хувьд тэдгээр хүчин зүйлүүдийн хоорондын хамаарлын талаар хийсэн төсөөллүүдийн улмаас VaR нь дутуу эсвэл илүү тооцоолж болно. Позицууд нь өдрийн туршид өөрчлөгдөөгүй байсан ч VaR нь зөвхөн ажлын өдөр дуусах үеийн байдлаарх багцын эрсдэлийг илэрхийлдэг ба 99 хувийн итгэлцлийн түвшнээс давсан аливаа нэг алдагдлыг тооцож үздэггүй.

VaR-ын хязгаар ба алдагдлын хэмжээ нь удирдлагаас тогтоож өгсөн хязгаарт байгаа эсэхийг тогтмол шалгаж үздэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгсэл дээр нэг өдрийн хугацаанд гарч болох алдагдлын хэмжээг VAR аргаар тооцоолж гаргасныг дор үзүүлэв. Үүнд:

	Түүхэн загвар мян.төг	Монте Карло загвар мян.төг
2016.12.31-ний өдөр	1,080,338	1,046,202
2016 оны өдрийн дундаж	623,083	613,683
2016 оны дээд хэмжээ	1,342,172	1,295,735
2016 оны доод хэмжээ	294,829	285,290
2015.12.31-ний өдөр	257,139	257,139
2015 оны өдрийн дундаж	395,236	392,425
2015 оны дээд хэмжээ	1,782,876	1,782,933
2015 оны доод хэмжээ	15,911	15,802

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2016.12.31 ба 2015.12.31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, валютаар	Төгрөг МЯН.ТӨГ	Ам.доллар МЯН.ТӨГ	Евро МЯН.ТӨГ	Бусад МЯН.ТӨГ	Нийт МЯН.ТӨГ
2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	168,659,289	88,752,625	1,129,452	29,876,813	288,418,179
Бусад банкн дахь харилцах, хадгаламж	82,616,952	46,947,884	3,878,799	8,763,332	142,206,967
Урвуу репо хэлцэл	2,998,768	—	—	—	2,998,768
Зээл ба урьдчилгаа	1,125,472,110	3,487,038	14,746	21,794	1,128,995,688
Санхүүгийн хөрөнгө оруулалт					
- борлуулахад бэлэн	312,901,235	114,718,056	—	—	427,619,291
- барьцаанд байгаа борлуулахад бэлэн	7,760,816	—	—	—	7,760,816
Бусад хөрөнгө	2,303,993	7,517,144	1,303	16,479	9,838,919
	1,702,713,163	261,422,747	5,024,300	38,678,418	2,007,838,628
Өр төлбөр					
Банкуудын харилцах, хадгаламж	47,153,275	78,625,473	319,275	1,041,375	127,139,398
Репо хэлцэл	7,722,342	—	—	—	7,722,342
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	6,997	—	—	—	6,997
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,175,865,962	139,680,449	4,434,756	31,636,921	1,351,618,088
Зээлээр авсан эх үүсвэр	350,122,625	1,736,500	—	—	351,859,125
Бусад өр төлбөр	6,377,850	517,368	231,899	63,741	7,190,858
	1,587,249,051	220,559,790	4,985,930	32,742,037	1,845,536,808
Цэвэр позиц	115,464,112	40,862,957	38,370	5,936,381	162,301,820

ТӨРИЙН БАНК ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, валютаар	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Евро мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	218,897,974	62,825,369	770,182	15,590,685	298,084,210
Бусад банкин дахь харилцах, хадгаламж	15,684,495	84,748,872	847,588	4,670,729	105,951,684
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	409,584	-	-	-	409,584
Зээл ба урьдчилгаа	916,004,424	8,427,952	1,029	14,069	924,447,474
Санхүүгийн хөрөнгө оруулалт					
- борлуулахад бэлэн	190,698,943	30,338,752	-	-	220,733,145
- дуусгавар хугацаа хүртэл эзэмших	39,559,921	19,640,914	-	-	59,200,835
Бусад хөрөнгө	2,400,631	7,327,723	8,888	13,600	9,750,842
	1,383,655,972	213,309,582	1,627,687	20,289,083	1,618,577,774
Өр төлбөр					
Банкуудын харилцах, хадгаламж	136,510,228	47,865,253	22	66,196	184,441,699
Репо хэлцэл	-	-	-	-	-
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	6,152	-	-	6,152
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,062,135,458	76,650,201	2,397,199	8,313,568	1,149,496,426
Зээлээр авсан эх үүсвэр	191,177,371	1,491,736	-	-	192,669,107
Бусад өр төлбөр	6,728,780	58,525	28,125	2,836	6,818,266
	1,396,551,837	126,071,867	2,425,346	8,382,600	1,533,431,650
Цэвэр позиц	(12,895,865)	87,237,715	(797,659)	11,906,483	85,146,124

Урьдчилан төлөлтийн эрсдэл

Урьдчилан төлөлтийн эрсдэл гэдэг нь Банкны үйлчлүүлэгч ба харилцагч нь хүлээж байснаас өмнө эсвэл хойно төлбөрөө хийх эсвэл төлбөр хийхийг хүссэний улмаас Банк санхүүгийн алдагдалд орох эрсдэл юм.

Банк нь төрөл бүрийн түвшний урьдчилан төлөлтүүдийн хүүний цэвэр орлогод үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолохдоо хялбаршуулсан аргыг авч хэрэглэдэг.

Хэрэв бусад бүх хувьсагчдыг тогтмол гэж үзэн эргэн төлөгдөх санхүүгийн хэрэгслийн 20% нь жилийн эхэнд урьдчилан төлөгдсөн бол тайлант жилийн хүүний орлого 34,285 сая төгрөгөөр буурахаар байсан байна. (2015: 34,332 сая төгрөг).

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хувь хүний санамсаргүй болон санаатай үйлдэл болон бусад гадаад хүчин зүйлүүдийн улмаас Банк алдагдалд орж болох эрсдэл юм. Хяналт алдагдах үед үйл ажиллагааны эрсдэл нь нэр хүнд унах, хуулийн болон зохицуулалтын асуудалд орох, улмаар санхүүгийн алдагдалд ороход ч хүргэж болно. Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдэлийг удирдаж болно. Хяналтад ажил үүргийн хуваарь, хяналттай системд нэвтрэх, тулган баталгаажуулах журмууд, боловсон хүчний боловсрол, үнэлгээний үйл явцууд багтана. Мөн дотоод аудиторын ажлыг ашиглах явдал орно.

29.5 Улс орны эрсдэл

Банк нь зөвхөн Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын түүхийн эдийн зах зээлийн уналтаас үүссэн эдийн засгийн уналтаас болж Монгол улсын засгийн газар 2016 оны хоёрдугаар хагасаас эхлэн Олон улсын валютын сан(ОУВС)-гаассанхүүгийн тусламж хүссэн. Жилийн эцэсээс хойш Засгийн газар улс орны санхүүгийн системийг бэхжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ОУВС-тай зөвшилцсөн. Энэ хүрээнд тус хөтөлбөрийн Банкны аливаа үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар нь одоогоор тодорхой бус байна.

30. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ**Бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн түвшинг тодорхойлох**

Бодит үнэ цэнэ гэдэг нь дампуурсан болон албадан борлуулахад хүрсэн этгээдээс бусад аливаа сонирхож буй талуудын хооронд, санхүүгийн хэрэглүүрийг зах зээл дээр арилжаалагдах дүн юм. Зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно.

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнийн түвшнээр нь ангилан үзүүлэв.

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
2016.12.31-ний өдрөөр				
Санхүүгийн хөрөнгө				
Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн	6,374,165	421,233,921	11,205	427,619,291
Дахин үнэлсэн хөрөнгө	—	—	61,933,925	61,933,925
Нийт	6,374,165	421,233,921	61,945,130	489,553,216
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	—	6,997	—	6,997
Нийт	—	6,997	—	6,997
2015.12.31-ний өдрөөр				
Санхүүгийн хөрөнгө				
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	—	409,584	—	409,584
Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн	6,075,494	214,652,325	5,326	220,773,145
Дахин үнэлсэн хөрөнгө	—	—	61,667,477	61,667,477
Нийт	6,075,494	215,061,909	61,672,803	282,810,206
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	—	6,152	—	6,152
Нийт	—	6,152	—	6,152

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**1, 2 болон 3 дугаар түвшний хоорондох хөдөлгөөн**

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн, санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн 1, 2 болон 3 дугаар түвшний хооронд хөдөлгөөн гараагүй болно.

3-дугаар түвшингийн санхүүгийн хэрэгслүүдэд орсон хөдөлгөөнийг доорх хүрснэгтүүдэд харуулав:

Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгсэл

	2016 мян.төг	2015 мян.төг
1 дүгээр сарын 1	5,326	520,954
Худалдан авалт	5,879	–
Борлуулалт	–	(515,628)
12 дугаар 31	11,205	5,326

Дахин үнэлсэн хөрөнгө

	2016 мян.төг	2015 мян.төг
1 дүгээр сарын 1	61,667,477	56,718,782
Нэмэгдсэн	2,252,473	7,313,629
Тухайн жилийн элэгдэл	(1,986,025)	(1,832,087)
Борлуулалт	–	(532,847)
12 дугаар 31	61,933,925	61,667,477

Хөрөнгийн биржид бүртгэлгүй борлуулахад бэлэн хувьцаа

Бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй тул 3 дугаар түвшний санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тооцоолох таамаглалын боломжит өөрчлөлтийн нөлөөг өртгөөр нь бүртгэсэн.

Хөрөнгийн дахин үнэлгээ

Барилга байгууламж болон газрын бодит үнэ цэнийг тогтоохын тулд зах зээлийн үнийн аргачлал ашигласан. Үнэлгээчин үнэлгээ хийхдээ зах зээл дээр байгаа ижил төстэй барилга байгууламжийн тооцоолсон худалдах өртөгт үндэслэсэн. Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хараат бус мэргэшсэн үнэлгээчид болох консорциум компаниудын үнэлгээн дээр үндэслэсэн байна.

Хэрэв зах зээлийн үнэ нь 2% -иар өсвөл үнэлсэн хөрөнгийн бодит үнэ нь 1,238,678 мян.төгрөг (2015онд 1,200,436 мян.төгрөг) өсөхөөр байна.

Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглах аргачлал, таамаглалыг доор харуулав.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө

Хөрвөх чадвар сайтай эсвэл эргэн төлөгдөх хугацаа богинотой (нэг жилээс богино хугацаатай) аливаа санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд дансны үнэ цэнийг түүний бодит үнэ цэнээр ойролцоолон авч үздэг. Удирдлагын гүйцэтгэсэн бодит үнэ цэнийн үнэлгээг харахад, нэг жилээс дээш хугацаатай банк, санхүүгийн байгууллагаас татсан бодит үнэ цэнийг санхүүгийн тайланд түүний дансны үнэ цэнээр ойролцоолон тавьсан байна. Энэ нь адил төстэй хадгаламжийн бүтээгдэхүүнд ногдож байгаа өнөөгийн зах зээлийн хүү нь зах зээлд анх гаргасан хүүнээс огцом өөрчлөгдөхгүй гэсэн зарчим, баримтаас үүдэлтэй.

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэл

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг Монгол улс дахь ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдийн одоогийн зах зээлийн хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүтэй харьцуулан тооцно. Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй Банкны санхүүгийн хэрэгслүүдийг ангилал бүрээр нь дансны болон бодит үнэ цэнээр нь харьцуулан дараах хүснэгтээр харууллаа. Энэхүү хүснэгтэд санхүүгийн бус хөрөнгө болон санхүүгийн бус өр төлбөрийн бодит үнэ цэнийг оруулаагүй болно.

Бодит үнэ цэнэ болон дансны үнийн хооронд ихээхэн зөрүүтэй үед Банкны санхүүгийн хэрэгсэлийг дансны болон бодит үнэ цэнээр нь харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ мян.төг
Санхүүгийн хөрөнгө		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,128,995,688	1,045,783,459
	1,128,995,688	1,045,783,459
Санхүүгийн өр төлбөр		
Зээлээр авсан санхүүжилт	336,865,287	327,423,346
	336,865,287	327,423,346
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр		
Санхүүгийн хөрөнгө		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	924,447,474	898,571,873
Санхүүгийн хөрөнгө оруулалт-дуусгавар хугацаа хүртэл эзэмших	59,200,835	58,251,647
	983,648,309	956,823,520
Санхүүгийн өр төлбөр		
Зээлээр авсан санхүүжилт	192,669,107	186,523,472
	192,669,107	186,523,472

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**30. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ****Банкны гол удирдах албан тушаалтнуудтай хийсэн ажил гүйлгээ**

Тайлант жилийн турш Банкны захирлууд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгосон нийт олговрын дүнг дараах хүснэгтээс харна уу. Үүнд:

	2016 мян.төг	2015 мян.төг
<i>Богино хугацаат тэтгэмж:</i>		
Цалин	1,580,275	984,567
Эрүүл мэнд нийгмийн даатгалын сан	46,066	47,592
Урамшуулал	623,634	290,408
	2,249,975	1,322,567
<i>Зээл болон харилцах, хадгаламж:</i>		
Гол удирдах албан тушаалтнуудад олгосон зээл	517,788	1,555,932
Гол удирдах албан тушаалтнуудын байршуулсан харилцах, хадгаламж	124,950	52,340

Банкны бизнесийн ердийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд гол албан тушаалтнууд үндсэн үүргээ гүйцэтгэж байсан боловч үндсэн ажлаа хийж байгаа бусад ажиллагсад, ажилтнуудтай харьцуулбал зээлийн хүү болон барьцааны хувьд нэлээд ялгаатай байна. Эргэн төлөлт эсвэл бусад тааламжгүй нөхцөлүүдээс илүү ялгарах онцлог байхгүй.

Гол удирдах албан тушаалтнуудад олгосон зээл болон урьдчилгаа нь барьцаатай бөгөөд жилийн 6%-иас 22.8% (2015 онд 5.4%-иас 24%) хувийн хүүтэй ба 1-ээс 20 хүртэл жилийн эргэн төлөгдөх хугацаатай байна. Уг санхүүгийн жилд эдгээр зээлээс олсон хүүний орлого нь 30.9 сая төгрөг болно (2015 онд 193.89 сая төгрөг).

Гол удирдах албан тушаалтнуудын харилцах, хадгаламж нь жилийн 2.0%-иас 15.6%-ийн хүүтэй байсан (2015 онд 2.0%-иас 15.0% байсан). Тухайн санхүүгийн жилд эдгээр харилцах, хадгаламжид 2.1 сая төгрөгийн хүүний зардал төлсөн (2015 онд 5.6 сая төгрөг).

Банкны хувьцаа эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ

2016оны болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, Банк нь бизнесийн ердийн үйл ажиллагааныхаа хүрээнд дараах голлох ажил гүйлгээнүүдийг Банкны хувьцаа эзэмшигчидтэй хийсэн байна. Эдгээр ажил гүйлгээг арилжааны нөхцлөөр зах зээлийн ханшаар гүйцэтгэсэн.

	2016 мян.төг	2015 мян.төг
Хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж	58,782,604	59,559
Хувьцаа эзэмшигчдээс авсан зээл	75,266,658	79,410,545
Хоёрдогч өглөг	65,000,000	—

Хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж нь жилийн 4.0%-иас 9.0%-ийн хүүтэй байсан. Тухайн санхүүгийн жилд эдгээр харилцах, хадгаламжид 2,288 сая төгрөгийн хүүний зардал төлсөн (2015 онд 677 сая төгрөг).

Хувьцаа эзэмшигчдээс авсан зээл нь жилийн 1.5%-иас 5.8%-ийн хүүтэй байсан. Тухайн санхүүгийн жилд эдгээр зээлд 3,730.6 сая төгрөгийн хүүний зардал төлсөн (2015 онд 2,573.82 сая төгрөг).

Хоёрдогч өглөг нь хүүгүй, хугацааны эцэст нэгж үнэ нь нэг сая төгрөг бүхий Төрийн банкны 65,000 ширхэг хувьцаанд хөрвөх нөхцөлтэй байна. Тодруулга 26-г харна уу.

Монголбанктай хийсэн ажил гүйлгээ

	2016	2015
	мян.төг	мян.төг
Монголбанк дахь харилцах	220,708,767	246,178,456
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл – хөрөнгө	–	409,584
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл – өр төлбөр	6,997	6,152
Монголбанкны үнэт цаас	–	9,975,131
Репо хэлцэл	7,722,342	–
Зээлээр авсан санхүүжилт	113,309,814	54,975,403

Уг санхүүгийн жилд Монголбанкнаас авсан хүүний орлого болон төлсөн хүүний зардал нь тус тус 8,008 сая төгрөг ба 3,390 сая төгрөг байсан (2015 онд 7,067 сая төгрөг ба 4,386 сая төгрөг байсан).

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний нөхцлүүд

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурьдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Тайлант жилийн эцсээрх зээл болон урьдчилгаанаас бусад үлдэгдэл дүн барьцаа хөрөнгөгүй болно. Бусад холбоотой талуудын өглөг эсвэл авлагын дүнд ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй. 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жилүүдэд Банк өөрийн холбоотой талуудтай холбоотойгоор найдваргүй авлагын сан байгуулаагүй болно.

Банк нь НББОУС 24-ийн өөрчлөлт болох “Төрийн оролцоот байгууллагуудын хувьд шаардлагатай тодруулгын хэсэгчилсэн хөнгөлөлт” хэсгийг хэрэгжүүлсэн. Иймд төрийн оролцоот байгууллагуудтай хийсэн дангаар материаллаг бус ажил гүйлгээнүүд нь санхүүгийн тайлангийн тодруулгад тусгагдаагүй болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараах хүснэгтэнд Банкны хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх, барагдах хугацаагаарх шинжилгээг харуулсан байна. Тодруулга 29.3 “Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага”-аас Банкны зүгээс барагдуулах бууруулж тооцоогүй гэрээт үүргүүдийг харна уу.

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкин дах харилцах	288,418,179	–	288,418,179
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	141,056,957	1,150,010	142,206,967
Урвуу репо хэлцэл	2,998,768	–	2,998,768
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	384,986,038	744,009,650	1,128,995,688
Санхүүгийн хэрэгсэл -			
- борлуулахад бэлэн	207,328,677	220,290,614	427,619,291
- барьцаанд буй борлуулахад бэлэн	7,760,816	–	7,760,816
Бусад хөрөнгө	3,847,604	7,302,836	11,150,440
	1,036,397,039	972,753,110	2,009,150,149
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	1,628,119	–	1,628,119
Үндсэн хөрөнгө	–	78,914,811	78,914,811
Биет бус хөрөнгө	–	1,962,475	1,962,475
	1,628,119	80,877,286	82,505,405
Нийт	1,038,025,158	1,053,630,396	2,091,655,554

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	127,139,398	–	127,139,398
Репо хэлцэл	–	7,722,342	7,722,342
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	6,997	–	6,997
Харилцагчдын харилцах, Хадгаламж	1,209,855,527	141,762,561	1,351,618,088
Зээлээр авсан санхүүжилт	146,176,842	205,682,283	351,859,125
Бусад өглөг	7,190,858	–	7,190,858
Хойшлогдсон татварын өглөг	–	561,859	561,859
	1,490,369,622	355,729,045	1,846,098,667
Цэвэр*	(452,344,464)	697,901,351	245,556,887

2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкн дах харилцах	298,084,210	–	298,084,210
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	104,801,674	1,150,010	105,951,684
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	409,584	–	409,584
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	335,263,098	589,184,376	924,447,474
Санхүүгийн хэрэгсэл -			
- борлуулахад бэлэн	128,784,917	91,948,228	220,733,145
- дуусгавар хугацаа хүртэл эзэмших	39,559,920	19,640,915	59,200,835
Бусад хөрөнгө	2,448,006	7,302,836	9,750,842
	909,351,409	709,226,365	1,618,577,774
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	2,959,103	–	2,959,103
Үндсэн хөрөнгө	–	79,242,236	79,242,236
Биет бус хөрөнгө	–	2,117,907	2,117,907
Хойшлогдсон татварын хөрөнгө	–	47,849	47,849
	2,959,103	81,407,992	84,367,095
Нийт	912,310,512	790,634,357	1,702,944,869
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	184,441,699	–	184,441,699
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	6,152	–	6,152
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,057,996,831	91,499,595	1,149,496,426
Зээлээр авсан санхүүжилт	52,998,859	139,670,248	192,669,107
Бусад өглөг	6,818,266	–	6,818,266
	1,302,261,807	231,169,843	1,533,431,650
Цэвэр*	(389,951,295)	559,464,514	169,513,219

* Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн тодорхой ангиллыг гэрээний үүрэг дээр үндэслэсэн байна. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

ТӨРИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**33. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА**

Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өнгөрсөн жилийн турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Капиталын удирдлага

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба сөрөг цочролыг дааж чадах өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын нэгдүгээр зэрглэлийн өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2015 онд 9%), өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 14% (2015 онд 14%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан хөрөнгө болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 2016 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах хуудсанд үзүүлэв.

	2016	2015
Өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн харьцаа	13.50%	15.49%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	20.14%	17.11%
	2016	2015
	мян.төг	мян.төг
I-р зэрэглэлийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	113,000,000	113,000,000
Бусад сан	693,669	693,669
Хуримтлагдсан ашиг	50,865,293	39,811,176
Нийт I-р зэрэглэлийн хөрөнгийн дүн	164,558,962	153,504,845
II-р зэрэглэлийн хөрөнгө		
Дахин үнэлгээний нэмэгдэл	10,547,302	11,009,228
Нийгмийн хөгжлийн сан	956,832	956,832
Борлуулахад бэлэн нөөц	4,493,791	4,042,314
Хоёрдогч өглөг	65,000,000	—
Нийт II-р зэрэглэлийн хөрөнгийн дүн	80,997,925	16,008,374
Нийт капитал/капиталын суурь	245,556,887	169,513,219

2016 болон 2015 оны 12-р сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн хөрөнгийг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

%	2016		2015	
	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг
0	661,376,123	–	589,008,905	–
20	45,061,370	9,012,274	23,127,114	4,625,423
50	310,157,997	155,078,999	203,844,277	101,922,139
70	121,730,889	85,211,622	76,448,228	53,513,760
100	966,823,491	967,348,491	804,957,528	804,957,528
120	1,689,065	2,026,878	4,978,406	5,974,087
150	244,606	366,909	13,187,350	19,781,025
Нийт	2,107,083,541	1,219,045,173	1,715,551,808	990,773,962

34. ТАЙЛАНГИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Удирдлага нь тайлангийн өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх ямар нэгэн үйл явдлыг олж илрүүлээгүй болно.

35. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.